



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хүснэгт:

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БҮЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
Стратегийн төлөвлөгөөний зорилго 1. “Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ.”							
Зорилт 1 Гэр хорооллын өрхүүдийн ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. (ЗГҮАХ 3.7.11, ДЗДҮАХ 5.6.4)							
1	Арга хэмжээ:1.1 Гэр хорооллын шаардлагатай байршлуудад ундны усны худаг гаргах, засварлах ажлыг хэрэгжүүлнэ.	380.0	Шинээр баригдсан худаг, тоо	8 /2021-2023 он/	6	Дүүргийн төсвийн 380 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Шинээр гүний худаг байгуулах ажил (13, 14 дүгээр хороо)” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр “Баялаг говь” ХХК шалгарч, гэрээний дагуу загвар зураг батлагдан, гүний худаг өрөмдөх ажил эхэлсэн. Дээрх төсөл, арга хэмжээний хүрээнд 13, 14 дүгээр хороонд 6 байршилд шинээр смарт ажиллагаатай гүний худаг ашиглалтад оруулна. Ажлын явц 70 хувь.	85%
		150.0	Смарт төхөөрөмж	6 /2021-2023 он/	6	Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 гүний худагт ухаалаг	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БҮЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
			суурилуулж засварласан худаг, тоо			төхөөрөмж суурилуулж смарт ажиллагаатай болгох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд; Нийслэлийн төсвийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хан- Уул дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хороонд нийт 11 гүний худгийн барилгын гадна, дотор засвар, ухаалаг төхөөрөмж суурилуулах ажлыг "Эйч Ти Эл" ХХК гүйцэтгэж дууссан. Комисс ажиллах шатанд байна. Дүүргийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх "Гүний худгуудыг смарт ажиллагаатай болгох, засварлах ажил (12, 13 дугаар хороо)" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр "Баялаг говь" ХХК ажиллаж байна. Ажлын явц 30 хувь.	
Зорилт 2 Үерийн хамгаалалтын далан сувгийг шинэчлэх болон шинээр барьж байгуулна. (ЗГҮАХ 3.7.12, ДЗДҮАХ 5.5.2)							
2	Арга хэмжээ: 2.1 Шаардлагатай байршилд ус зайлуулах суваг, далан барьж байгуулна.	450.0	Ашиглалтад орсон ус зайлуулах су вгийн урт, метр	1500 /2021-2023 он/	200	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 6 байршилд нийт 2630 метр урт борооны ус зайлуулах суваг, далан байгуулсан. Үүнд: 1. 15-р хороо, Төв цэнгэлдэх хүрээлэн орчимд борооны ус зайлуулах 1200 метр урт шугам сүлжээг угсарч ашиглалтад оруулсан. 2. 8-р хороо, Архивчдын гудамжинд авто замын борооны ус зайлуулах 423 метр урт ган болон хуванцар хоолой бүхий шугам сүлжээг угсарч ашиглалтад оруулсан.	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>3. 21-р хороо, Жаргалантын амны үлдэгдэл 800 метр далангийн ажил хийгдэж дууссан</p> <p>4. 1-р хороо, Эрлийн байрны урд талын туслах авто замын борооны ус зайлуулах худгуудыг шинэчлэсэн.</p> <p>5. 3-р хороо, Дунд гол дагуу Шунхлай ШТС-ыг буулгаж 3.2 метр өндөр, 207 метр урт үерийн хамгаалалтын даланг шинээр барьсан.</p> <p>6. 1-р хороо, Наран хотхон, Петровисын шатахуун түгээн станц орчмын авто замын борооны ус зайлуулах шугам, Энхтайваны гүүрэн доорх гаргалгаа шугамыг өргөтгөх ажил хийгдсэн.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2024 оны А/322 дугаар захирамжийн дагуу Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ 21.2 сая төгрөгийн хөрөнгөөр "Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, үерийн ус зайлуулах лотки суурилуулах, үерийн хамгаалалтын далан засварлах ажил"-ын хүрээнд 1004 м.куб үерийн ус чиглүүлэгч далан барих, 66 метр замын гадаргуугийн ус зайлуулах сувгийн тэвш байрлуулах ажил хэрэгжиж дууссан.</p> <p>Мөн дүүргийн төсвийн хөрөнгөөр 13, 14 дүгээр хороодын авто зам дагуух үерийн далангийн засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөв боловсруулагдаж дууссан бөгөөд 2, 3, 11, 12, 15, 24-р хороодын нутаг дэвсгэрт борооны болон үерийн далан шуудуу шинэчлэх ажлын зураг</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						төсөв боловсруулах ажил хийгдэж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 8-р хорооны "Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал" хүртэлх авто замын 2 талаар 1 км урт, 20-р хорооны Мишээл экспогийн баруун талд орон сууц хороолол доторх замын 0.23 км урт, 16-р хорооны Тайнь 2 дугаар гудамжнаас Буянт-Ухаа 23 дугаар гудамж хүртэл авто замын 0.29 км урт нийт 1.52км урт борооны ус зайлуулах далан, суваг хийгдсэн.	
3	Арга хэмжээ: 2.2 Үерийн эрсдэлээс хамгаалах зөөврийн тоног төхөөрөмж худалдан авах	200.0	Худалдан авсан зөөврийн төхөөрөмжийн төрөл, тоо	-	4	Дүүргийн төсвийн 200 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжиж буй үерийн эрсдэлээс хамгаалах зөөврийн тоног төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгчээр "Престиж Инженеринг" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Дүүргийн Онцгой байдлын хэлтэст дараах тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Үүнд: 1. Тус бүр нь 3 метрийн урттай ус шингээгч үерийн далан 150 ширхэг. 2. Тус бүр нь 52 сантиметрийн өндөр, 30-60 сантиметрийн өргөнтэй зөөврийн үерийн босоо далан 480 ширхэг. 3. Тус бүр нь 10 метрийн урттай зөөврийн үерийн далан 24 ширхэг. 4. Тус бүр нь 10 метр урт, 1 метрийн өргөнтэй зөөврийн хийлдэг гүүр 10 ширхэгийг тус тус хүлээлгэн өгсөн.	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
4	Арга хэмжээ: 2.3 Автобусны буудлын засвар тохижилтын ажил хэрэгжүүлнэ	1,180.0	Засварласан автобусны буудлын байршил, тоо	2	8	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээний хүрээнд 3, 6, 8, 11, 13 хорооны 12 байршилд автобусны буудал барьж ашиглалтад оруулсан.	100%
Зорилт 3 Явган хүний болон унадаг дугуйн зам, авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулан, тоосжилтыг бууруулна. (ЗГҮАХ 6.1.7)							
5	Арга хэмжээ: 3.1 Явган хүний зам болон дугуйн зам шинээр барина.	650.0	Явган хүний замын урт, км	-	1.5-аас багагүй	Нийслэл, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10 төсөл арга хэмжээний хүрээнд 11 км урт талбайд явган хүний замын ажлыг хэрэгжүүлсэн. Үүнд: Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3-р хороо, Ажилчны гудамжны 2.5 км явган хүний замыг засварлаж, шинэчилсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 23-р хороо Наадамчдын замаас Хангарьд сити 2 хороолол хүртэлх 1.1км, 10, 16, 25-р хороо Нисэхийн эцсийн авто замын дагуу 0.5км, 1,3,15-р хороо Явган зам талбайн тохижилт 0.7км, 9,16-р хороо Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, тохижилтын ажил 0.7 км, 23-р хороо Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн авто зам дагуу 2.2 км, 3-р хороо Наадамчдын замаас Говийн авто зам хүртэлх 1.1км, 8-р хороо Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал хүртэлх 1.7 км, 24-р хороо Явган зам, замын байгууламжийн ажил 0.13 км,	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						22-р хороо Номун виллаж хотхон, Могул таун хотхонд шинээр явган хүний зам тавих, 0.28 км 20-р хороо Мишээл Экспогийн баруун талын орон сууцны хороолол хүртэлх авто зам дагуу 0.17 км урт дугуйн замыг тус тус ашиглалтад оруулсан. Гүйцэтгэлийн шатанд хэрэгжиж буй 1 төслийн хүрээнд 3.1 км урт явган зам: Явган хүний зам талбайн засвар, шинэчлэлт /11, 19, 20-р хороо/ явц 70%.	
		-	Дугуйн замын урт, км	-	0.6-аас доошгүй	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5 байршилд шинээр 5.5 км урт дугуйн замын ажлыг шинээр хэрэгжүүлсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1.6 км урт дугуйн замыг өргөтгөн шинэчилсэн.Үүнд: Дүүргийн төсвийн хөрөнгөөр 23-р хороо Нэгдсэн эмнэлэгийн зүүн урд уулзвараас Хангарьд сити 2 хороолол хүртэлх 0.42км, Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн авто зам дагуу 2.2 км, 3-р хороо Наадамчдын замаас Говийн авто зам хүртэлх 1.1 км, 8-р хороо Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал хүртэлх 1.7 км, 20, 24-р хороонд Яармагийн гүүрийг Эко зурвастай холбосон дугуйн зам шинээр 0.13 км урт дугуйн замыг тус тус ашиглалтад оруулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15-р хороо Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 120 мянгатын уулзвараас	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						Орчлон сургууль хүртэл 1.6 км урт дугуйн замыг өргөтгөн шинэчилсэн.	
Зорилт 4 Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ. (ЗГҮАХ 6.2.6)							
6	Арга хэмжээ: 4.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	-	Иргэдээс ирүүлсэн санал, тоо	2023 онд 105,488 санал авсан.	106,000	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хийгдэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтээс цахимаар санал авах ажлын 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж байна. Санал асуулга явагдаж буй хугацаанд хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт шинээр аппликейшин ашиглалтад орсонтой холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын явцын мэдээллийг танилцуулж, “e-mongolia”, “Орон нутгийн хөгжлийн сан” аппликейшинээр санал өгөх заавар зөвлөмж өгч ажилласан. Дүүргийн хэмжээнд 24 төсөл, арга хэмжээний хүрээнд 99,453 иргэнээс цахим болон цаасан хэлбэрээр санал авсан.	95%
Зорилт 5 Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох “Зөв шийдэлтэй” дахин төлөвлөлтийг системтэйгээр хийнэ. (НЗДҮАХ 6.1.7)							
7	Арга хэмжээ: 5.1 Нийтийн зориулалттай хуучин орон сууцны фасадыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн, шинэчилсэн байна.	2,545.3	Засварласан байрны тоо,	9 /2021-2024 он/	5	Нийтийн зориулалттай орон сууцны фасад засварын ажлын хүрээнд 2023-2024 он дамжин хэрэгжсэн 8 байр, шинээр 1 байр, нийт 9 байрны фасад засварын ажил бүрэн хийж дууссан. Үүнд: 2-р хорооны 20-р байр, 10-р хорооны 1, 7, 61/1, 61/2, 62, 63, 64-р байр, 12-р хорооны 52-р байрны фасадыг тус тус засварлаж дууссан.	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажлын хүрээнд 2023-2024 он дамжин хэрэгжсэн 15 байр, шинээр 13 байр нийт 28 байрны дээвэр засварын ажил хийгдэх ажил үргэлжилж байна, 26 байрны дээврийг засварлаж дууссан. Үүнд: 1-р хороо 42-р байр, 3-р хороо 50-р байр, 15-р хороо 19, 21, 49-р байр, "Жаргалан хотхон" 2, 49б, 49а, Модерн таун хотхон 25-байр, 24-р хороо, 107-р байр, 19-р хороо 27/1, 15/1, 15/2, 86, 87, 88, 96-р байр, 25-р хороо 703, 706, 714, 715, 719, 722, 725, 726, 727-р байрны дээврийг тус тус засварлаж дууссан.	
Зорилт 6 Ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. (НЗДҮАХ 6.1.7)							
8	Арга хэмжээ: 6.1 Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах, хэрэгцээт төхөөрөмжөөр хангах ажлыг хэрэгжүүлнэ.	22,000.0	Нэмэгдүүлсэн суудал, тоо	5260 /2021-2023 он/	2240	Хан-Уул дүүрэгт 2023-2024 онд гадаадын тусламж, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 7840 хүүхдийн суудалтай 12 сургууль баригдахаар төлөвлөгдсөнөөс АХБ болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3-р хороо, 18-р сургууль, 19-р хороо, 115-р сургуулийн тус бүр 320 хүүхдийн суудалтай 2 өргөтгөлийн барилга, 12 дугаар хороо 10 дугаар сургуулийн 640 суудалтай сургуулийн барилга ашиглалтад орсон. Үлдсэн 9 сургуулийн барилгын ажлын явцыг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал: 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай 2, 8 дугаар хороонд баригдаж буй нийт 1280 суудалтай 2	100%
		-	Ашиглалтад орсон сургууль, тоо	8	4		

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						сургуулийн барилгын ажлын явц дунджаар 65%, 2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалттай 4, 16, 17, 18, 23 дугаар хороонд баригдах 4160 суудалтай 5 сургуулийн барилгын ажил 45%, 3. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалттай 3, 16 дугаар хороонд баригдах 1120 суудалтай 2 барилгын явц 10%-тай хэрэгжиж байна.	
		322,000	Засварласан сургуулийн барилга, тоо	1	1	Сурагчдын эрүүл, аюулгүй орчинд сурах нөхцлийг хангах ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 26 дугаар сургуулийн гадна фасад засварын ажлын гүйцэтгэгчээр “Глобал гейтвей” ХХК шалгарсан бөгөөд гадна фасадыг бүрэн засварлаж дууссан.	
		553,680	Тоног төхөөрөмжөөр хангагдсан сургууль, тоо	-	4	Боловсролын байгууллагын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4 багц төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Ажлын явцаар авч үзвэл: -“Боловсролын байгууллагуудын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн (ХУД)” төсөл, арга хэмжээний хүрээнд 48 нэр төрлийн 449 ширхэг тоног төхөөрөмж, тавилга хэрэглэгдэхүүн нийлүүлэгдсэн. Багц-1 гүйцэтгэгч Чиглэл ХХК, Багц-2 гүйцэтгэгч Голденхоул ХХК, Багц-3 гүйцэтгэгч Цуурай ХХК нийлүүлсэн. -“Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тоног төхөөрөмж (ХУД)	

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>Багц-3” төсөл, арга хэмжээний хүрээнд 23 нэр төрлийн хөгжих, хэрэглэгдэхүүн нийлүүлэхээр төлөвлөсөн. Гүйцэтгэгч шалгаруулах шатанд байна.</p> <p>-Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн Урлаг зааланд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл (ХУД, 4 дүгээр хороо) төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Өүби жийн цент ХХК шалгарч, тавилга нийлүүлэгдсэн.</p> <p>- Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж (Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо) гүйцэтгэгчээр Егү говь ХХК шалгарч, тавилга нийлүүлэгдсэн.</p> <p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Ажлын явцаар авч үзвэл:</p> <p>- “Ерөнхий боловсролын 15, 52, 89, 115 дугаар сургуульд шаардлагатай үндсэн болон туслах тоног төхөөрөмж худалдан авах” 4 багц төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Чиглэл ХХК шалгарч гэрээ байгуулсан. Гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.</p> <p>- “Боловсролын байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт” төсөл, арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт 1000 зөөврийн компьютер хүлээлгэн өгсөн.</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						- “Төрийн байгууллагын албан хэрэгцээнд тавилга тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээний хүрээнд 114-р сургуулийн урлаг зааланд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.	
		3,225.6	Нэмэгдүүлсэн ор, тоо	1770 /2021-2023 он/	2220	Хан-Уул дүүрэгт 2023-2024 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 3210 ортой 20 цэцэрлэгийн барилга, 1260 суудал, 700 ор бүхий 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга төлөвлөгдсөнөөс, АХБ-ний санхүүжилттэй 2 дугаар хороо, 72 дугаар цэцэрлэгийн 150 ортой өргөтгөл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20 дугаар хорооны 240 ортой цэцэрлэгийн барилга, 10 дугаар хороо 49 дүгээр цэцэрлэгийн 240 ортой цэцэрлэгийн барилга, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр хороо 12 дугаар цэцэрлэгийн 100 ортой ёс заншлын өргөө, 23 дугаар хороонд 150 ортой цэцэрлэгийн барилга, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15, 25 дугаар хорооны тус бүр 200 ортой цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсон бөгөөд нийт 1280 орны хүчин чадалтай 7 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Хэрэгжиж буй цэцэрлэгийн барилгын явцыг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал:	
		-	Ашиглалтад орсон цэцэрлэг, тоо	10 /2021-2023 он/	12	1. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай 1, 4, 5, 18 дугаар хороонд	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						баригдаж буй нийт 810 ортой 5 цэцэрлэгийн барилгын ажлын явц 60%, 2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8, 14, 16, 24 дүгээр хороонд баригдах 820 ортой 4 цэцэрлэгийн барилгын ажил 65%, 8, 9, 12, 14, 16 дугаар хороонд баригдаж буй 1260 суудал, 700 ор бүхий 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга 85%, 3. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9, 20, 23 дугаар хороонд 300 ортой 4 цэцэрлэгийн барилгын ажлын явц 30 хувьтай хэрэгжиж байна.	
Зорилт 7 Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр үе шаттай хангана. (ДЗДҮАХ 5.3.70)							
9	Арга хэмжээ: 7.1 12, 13, 14 дүгээр хороонд хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй өрхийг цахилгаан шугам, сүлжээнд холбоно.	1,840.0	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрх, тоо	151	300	Дүүргийн төсвийн хөрөнгөөр энэ онд шинээр 10, 12, 13, 14 дүгээр хороодын 855 өрхийн цахилгааны хүчдэлийг сайжруулах 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Ажлын явц, гүйцэтгэлээр авч үзвэл: Дүүргийн төсвийн 700 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 14 дүгээр хорооны Гавьжийн шанд хэсгийн 213 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажил хийгдэж дууссан. Дүүргийн төсвийн 186 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 14 дүгээр хорооны Ар хөндлөн хэсгийн 36 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлын гүйцэтгэгчээр “Гуулин энерги” ХХК шалгарч бөгөөд цахилгааны хүчдэл сайжруулах ажил	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						хийгдэж дуусан улсын ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангуулж байна. Ажлын явц 95%. Дүүргийн төсвийн 1.14 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 13 дугаар хорооны 380 орчим өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлын гүйцэтгэгчээр “Эйч Ар Ви констракшн” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Шон суурилуулах ажил хийгдсэн. Кабель шугам татах, тоноглол суурилуулах ажил хийгдэж байна. Ажлын явц 80%. Дүүргийн төсвийн 750 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 10, 12, 14 дүгээр хорооны 226 өрхийн цахилгааны хүчдэл ажлын гүйцэтгэгчээр “Бүрэн Холбоо констракшн” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Зураг төсөв боловсруулагдаж байна. Ажлын явц 30%.	
Зорилт 8 Үйлчилгээний жишигт нийцсэн Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг тодорхой бүсүүдэд барьж байгуулна. (ДЗДҮАХ 2.2.6)							
10	Арга хэмжээ: 8.1 10 дугаар хороонд өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг хэрэгжүүлнэ	2,000.0	Шинээр баригдсан өрхийн эмнэлэг, тоо	3 /2021-2024 он/	1	Дүүргийн төсвийн 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Элбэггүн” ХХК шалгарч, Барилга каркас угсралтын ажил болон дээврийн ажил хийгдэж дууссан.	50%
Зорилт 9 Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хуулийн дагуу хэрэгжүүлнэ.							
11	Арга хэмжээ: 9.1	-	Холбогдох хууль, журмын	-	Төсвийн төлөвлөлттэй	Хан-Уул дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	Дүүргийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг бодлогын баримт бичгүүд болон бусад эх үүсвэрийн төсвийн төлөвлөлттэй уялдуулан боловсруулж батлуулна.		шаардлагыг хангуулан хуулийн хугацаанд батлуулсан эсэх.		уялдуулан холбогдох хууль, журмын шаардлагыг хангуулан хуулийн хугацаанд батлуулсан байна.	төсөл, арга хэмжээний санал боловсруулж дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 20, 27-ны өдрийн 2 удаагийн зөвлөлийн хуралд танилцуулсан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулан хуулийн хугацаанд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулна.	
12	Арга хэмжээ: 9.2 Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт уламжилна.	-	Хуулийн хугацаанд саналыг боловсруулан хүргүүлсэн эсэх.	-	Саналыг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг дэргэдэх хэлтэс, алба, хороодоос авч нэгтгэн боловсруулж Төсвийн тухай хуулийн шаардлага хангасан батлагдсан зураг төсөвтэй 11 төсөл, арга хэмжээний саналыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 03/785 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын Газарт хүргүүлсэн. Мөн https://publicinvestment.gov.mn/ системд төсөл, арга хэмжээний мэдээллийг шивж оруулсан.	100%
13	Арга хэмжээ: 9.3 Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих эрх шилжиж ирсэн ажил болон дүүргийн төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлуудын ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, нэгжийн дарга	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	ДИТХ-аар шинээр хэрэгжүүлэх 80 төсөл, арга хэмжээг батлуулсан.	Төсөл, арга хэмжээнүүдийн тендер зарлахад шаардагдах баримт бичгүүдийн бүрдлийг хангуулж бүрэн	Нийслэлийн Засаг даргын 9 захирамжийн хүрээнд нийт 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх Хан-Уул дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Дээрх төсөл арга хэмжээний явцын хувьд гэрээ байгуулсан 7 төсөл, арга хэмжээ, үнэлгээ хийгдэж байгаа 1 төсөл, арга хэмжээ, тус тус 4 удаа тендер зарлаад гүйцэтгэгч	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	болон байгууллагын даргаар батлуулан Худалдан авах ажиллагааны албанд ажлын зураг төсөв болон холбогдох бусад материалын хамт шилжүүлнэ.				хүлээлгэн өгсөн байна.	шалгараагүй 2 төсөл, арга хэмжээ байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 113 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар тогтоолоор батласан бөгөөд 136 багц арга хэмжээ болгон задалсан. Ажлын явцаар авч үзвэл: Хэрэгжиж дууссан 59 төсөл, арга хэмжээ, гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 57 төсөл, арга хэмжээ, гэрээ байгуулах шатанд байгаа 3 төсөл, арга хэмжээ, худалдан авах ажиллагааны шатанд 13 төсөл, арга хэмжээ, холбогдох архитектур төлөвлөлтийн даалгавар хүлээгдэж байгаа 4 багц төсөл, арга хэмжээ байна.	
Зорилт 10 Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, агаарын чанарын хяналтыг сайжруулна. (ЗГҮАХ 5.1.1, НЗДҮАХ 5.2.1)							
14	Арга хэмжээ: 10.1 Агаарын бохирдлыг бууруулах зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг хийх, яндангийн тоог бууруулах, угаарын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргэх ажил зохион байгуулна.	16.0 (ДТХО)	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	6 удаагийн аян, арга хэмжээг зохион байгуулж, 68,000 ширхэг зөвлөмж сэрэмжлүүлэг хүргэсэн.	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1030 дугаар захирамжийн хүрээнд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14-р хорооны зорилтот бүлгийн 103 өрхийг угаар мэдрэгчээр хангасан. Нийслэлийн Экологийн цагдаагийн алба, дүүргийн онцгой байдлын хэлтэс, Таван толгой түлш ХХК-ийн хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хамтран “Шалгавал эрсдэлгүй” арга хэмжээг дүүргийн хэмжээнд сар бүр зохион	90%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>байгуулж, угаартах эрсдэл бүхий 8, 9, 12, 13, 14 дүгээр хорооны 234 айлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>"Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөв галлагааны чиглэлээр зөвлөмж мэдээлэл хүргүүлэх ажлыг 11, "Галлагаандаа анхааръя" аяныг 2 удаа зохион байгуулж, 15 хорооны 15248 өрхийг хамруулсан бөгөөд 6 төрлийн 72000 ширхэг гарын авлагыг иргэдэд хүргэсэн.</p> <p>Европын холбооны Switch Asia хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй гэр хорооллын хувийн сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгах "Дулаан шийдэл" төслийн хүрээнд Жэрэс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтарч ""Хялбар шийдэл"" аяныг өрнүүлж, дүүргийн 8, 9, 10, 13, 16 дугаар хорооны 50 байшинтай өрхийн дээвэр дулаалах, өрх толгойлсон 50 эмэгтэйчүүдийн байшингийн хаалга, цонхыг дулаалсан.</p>	
		280.0 ДТХО	Төвлөрсөн шугамд холбосон төрийн байгууллагын тоо	7 (2023 онд 6 дугаар хорооны байр, Цагдаагийн 2 дугаар хэлтэс, дүүргийн Нэгдсэн амбулатор, Шуудан холбоо, Гүн	1 (Яармаг худалдааны төв)	Дүүргийн төсвийн 280 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 дугаар хороонд байрлах Яармаг худалдааны төвийг төвлөрсөн цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох ажлын тендерийн зарлагдсан. Тендерийг 2024 оны 12 дугаар сарын 10-нд нээнэ.	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
				тэрэм мал эмнэлэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нэг цэг, “Чанд авиа” өрхийн эрүүл мэндийн төв)			
		-	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн нэгдсэн тоо бүртгэлд хамруулсан хорооны тоо	13 хороо (4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороо)-г тооллогод хамруулж, 16986 зуухны мэдээллийг шинэчилж, цахим бүртгэлийн санд оруулсан.	13 хороог тооллогод хамруулж (4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 22, 23 дугаар хороо) зуухны мэдээллийг цахим бүртгэлийн санд оруулна.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1313, Хан-Уул дүүргийн 2024 оны 01 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 06-наас 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд явуулсан. Тус тооллогоор 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 14039 зуух, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 1209 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 22 аж ахуйн нэгжийн 41 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан. Дээрх мэдээллийг 2022 оны тооллогын дүнтэй харьцуулбал, 3-15 кВт хүчин чадалтай зуухны яндангийн тоо 2189-өөр буурсан, 100-4200 кВт хүчин чадалтай уурын болон усан халаалттай зуухны байгууламжийн тоо 12-оор буурсан буюу 4 аж ахуйн нэгжийн 12 зуух татан буугдсан байна.	
Зорилт 11 Замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, авто замыг шинээр байгуулна. (ЗГҮАХ 6.1.6)							
15	Арга хэмжээ:11.1 Дүүргийн авто замын ачааллыг тэнцвэржүүлэх,	10,850.0	Шинээр тавьсан авто замын урт, км	18.1 км хатуу хучилттай авто зам	Шинээр 6 км-ээс доошгүй хатуу	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3 төслийн хүрээнд 4.37 км, дүүргийн төсвийн хөрөнгөөр 12 төслийн	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	<p>зорчих хөдөлгөөнийг сайжруулах зорилгоор хатуу хучилттай авто зам, зогсоолыг нэмэгдүүлэх, Эвдрэлтэй авто замыг нөхөж, засварлах, гэр хорооллын гудамж талбайг зохист найрлагат дайргаар засварлаж, тэгшлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>			<p>ашиглалтад орсон /2021-2023 он/</p>	<p>хучилттай авто зам тавигдсан байна.</p>	<p>хүрээнд 7.16 км, нийт 15 төсөл, арга хэмжээний хүрээнд 11.6 км хатуу хучилттай авто зам барилгын ажил хэрэгжүүлж байна. Үүнд: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хийгдэж дууссан 3 төсөл, арга хэмжээ: 1) Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох 0.64 км авто зам, 2) Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн 1.53 км авто өргөтгөл, шинэчлэлт 3) Чингисийн өргөн чөлөөнөөс баруун үйлдвэрийн гудамж хүртэлх нийт 2.2 км авто зам. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хийгдэж дууссан 4 төсөл, арга хэмжээ: 1) Хан-Уул дүүрэг 9-р хороо Төв замаас гэр хорооллын дундуур шинээр 0.46 км авто зам, 2) Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал хүртэлх 1.7 км авто зам (8-р хороо), 3) 290 дүгээр цэцэрлэгийн урд талд 6,500 м.кв талбайд авто зогсоол байгуулах ажил (21-р хороо), 4) Яармаг дэнжийн хэсэгт 2,370 м.кв талбайд автобусны буудал байгуулах (8-р хороо) Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 төсөл, арга хэмжээний хүрээнд 5 км авто замын ажил хийгдэж байна. Үүнд: 1) 20-р хороо, “Мишээл экспогийн баруун талд орон сууц хороолол руу</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БҮЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>орох 0.15 км замын ажил"-ын явган зам, гэрэлтүүлгийн ажил хийгдэж байна. Ажлын явц 85%.</p> <p>2) 12-р хороо, 121 дүгээр цэцэрлэг орчмын 1.09 км авто замын ажлын суурь асфальт хийгдсэн. Ажлын явц 80%.</p> <p>3) 10-р хороо, "Морингийн 1 дүгээр гудамжнаас хойшоо 0.71 км авто замын ажил"-ын суурь асфальт хийгдсэн. Ажлын явц 80%.</p> <p>4) 20-р хороо, Мишээл экспогийн баруун талд орон сууц хороолол доторх 0.4 км замын ажлын суурь асфальт хийгдсэн. Ажлын явц 80%.</p> <p>5) 16-р хороо, Тайнь 2 дугаар гудамжнаас Буянт-Ухаа 23 дугаар гудамж хүртэл 1км авто замын суурь асфальт хийгдсэн. Ажлын явц 80%.</p> <p>6) 13-р хороо, Төв замаас 26 дугаар сургууль хүртэлх 0.35 км авто замын суурийн ажил хийгдэж байна. Ажлын явц 40%.</p> <p>7) 9-р хороо, Баруун Сонголонгийн гудамжнаас Буянт-Ухаа 23 дугаар гудамж дагуу Центр хүртэлх 0.6 км авто замын суурийн ажил хийгдэж байна. Ажлын явц 40%.</p> <p>8) 20-р хороо, Чингисийн өргөн чөлөөнөөс туул голын гудамж хүртэлх авто замын суурийн ажил хийгдэж байна. Ажлын явц 40%.</p>	
		150.0 (ДТХО)	Авто зогсоолын багтаамж, тоо	-	100-аас доошгүй машины багтаамжтай	2024 онд нийт 9 байршилд 457 авто машины зогсоол шинээр байгуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15 дугаар хороо Төв цэнгэлдэх	

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>хүрээлэнгийн зүүн хойд талд 241 авто машины зогсоол ашиглалтад оруулсан.</p> <p>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023-2024 он дамжин хэрэгжүүлж буй 2, 3, 10, 19 дүгээр хороодын гарааш буулгасан 6 байршилд 63 авто машины зогсоол байгуулсан. Энэ онд шинээр 21 дүгээр хороо 290 дүгээр цэцэрлэгийн урд талбайд 130 авто машины зогсоол, 20 дугаар хороонд ашиглалтын шаардлага хангахгүй төр захиргааны байрыг буулгаж тохижилт хийх ажлын хүрээнд 53 авто машины зогсоол тус тус ашиглалтад орсон.</p>	
		300.0 (ДТХО)	Нөхсөн талбай, м.кв	Эвдрэлтэй авто замын 18514,8 м.кв талбайг нөхөж, засварласан.	3000 м.кв-аас багагүй талбайг нөхөж засварлана.	<p>Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15 байршилд 12 төсөл арга хэмжээ нийт 17.7 км авто замыг засварлаж шинэчлэсэн. Үүнд:</p> <p>Архивчдын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Нисэхийн тойргоос Нисэхийн хурдны зам), Нийслэл хүрээ өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (120 мянгатын Тэмээтэй хөшөөний уулзвараас зүүн тийш Е мартын уулзвар), Тоовангийн гудамжны авто замын засвар шинэчлэлт, УБЦТС ТӨХК-ийн баруун талын авто замын засвар шинэчлэлт, ХААИС-ийн уулзвараас Яармагийн гүүр хүртэлх Богд уулын авто замын засвар, шинэчлэлт, Маршалын гүүрнээс Буган халиун хүртэлх авто замын</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>засвар шинэчлэлт, Наадамчдын авто замын засвар шинэчлэлт урд хэсэг (Шунхлай ШТС-аас Титан төв хүртэл), Туул ривер хотхон орчмын зам талбайн засварын ажил (24-р хороо), Хороолол дундах авто зам засвар, шинэчлэлтийн ажил (1, 2-р хороо), Хороолол дундах зам засвар, шинэчлэлтийн ажил (15, 17-р хороо), Хороолол дундах зам засвар, шинэчлэлтийн ажил (19, 20-р хороо), ХААИС-ийн оюутны 1, 3-р барны урд талын авто замын засвар шинэчлэлт хийсэн.</p> <p>Нийслэлийн төсвийн 345.1 сая төгрөгийн хөрөнгөөр 15 байршилд 4313.9 м.кв талбайг нөхөж, засварлаж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/191 дүгээр захирамжийн дагуу Хан-Уул зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ гэр хороолол, орон сууц хороолол дундах туслах замуудын эвдрэлтэй 10000 м.кв талбайд нөхөлт хийн зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан.</p>	
		1,400.0 (ДТХО)	Зохист найрлагатай хайргаар засварлаж, тэгшилсэн талбай, м.кв	189,685 м.кв (2023 онд 63 гудамж талбайг хусаж, дайргаар засварлаж, тэгшилсэн.)	157,142 м.кв талбайг зохист найрлагатай хайргаар засварлаж, тэгшилнэ.	Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ дүүргийн гэр хорооллын 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 25 дугаар хороодод зорчиход хүндрэлтэй, эвдрэлтэй 170 гудамжны 452,768 м.кв талбайг хусаж, зохист найрлагатай хайрга, дайргаар засварласан.	
Зорилт 12 Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, стандартад нийцүүлэн, нэгдсэн удирдлагын автомат системд холбоно. (НЗДҮАХ 6.3.30, ДЗДҮАХ 5.1.4)							

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
16	Арга хэмжээ: 12.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хороололд 1000-аас доошгүй гэрэлтүүлгийг шинээр суурилуулж, нэгдсэн удирдлагын системд холбох, засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллана.	3,914.0 (ДТХО) 1,000.0 (ДОНХС)	Гэрэлтүүлгийн тоо	10497	нийтийн эзэмшлийн талбайд 1000-аас доошгүй гэрэлтүүлгийг суурилуулна.	Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто зам дагуу нийт 1760 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах 6 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд: Хэрэгжиж дууссан 3 төсөл, арга хэмжээ: Дүүргийн төсвийн хөрөнгөөр 13 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж талбайд 78 ширхэг гэрэлтүүлэг, 23 дугаар хороо, Наадамчдын авто замаас Нүхт чиглэлийн авто замд 16 ширхэг гэрэлтүүлэг, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3,4,5,6,7,8,10,11,12,13,14,16,19,23,24-р хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд 640 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажил тус тус хэрэгжиж дууссан. Хэрэгжиж буй 3 төсөл, арга хэмжээ: Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 2,5,8,9,10,11,12,13,14,16,21,23,24-р хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд 360 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажлын ажлын явц 90%, Гүйцэтгэгч "РЗА" ХХК. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 14, 21-р хороодын авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр 226 ширхэг гэрэлтүүлэг хийх ажлын явц 90%.	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>Гүйцэтгэгч “Өндрийн удам” ХХК. 10, 12, 13-р хороодын авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр 440 ширхэг гэрэлтүүлэг хийх ажлын явц 90%. Гүйцэтгэгч “Ингүүмэл эрчим” ХХК.</p> <p>Мөн нийслэл дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн авто зам, тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 3, 4, 5, 9, 10, 12, 22 дугаар хороодод 326 ширхэг гэрэлтүүлэг шинээр ашиглалтад орсон. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Наадамчдын замыг Эрчим хүчний гудамжтай (4, 5-р хороо) холбосон авто зам, гүүрийн ажлын хүрээнд дан болон хос толгойтой 191 ширхэг гэрэлтүүлэг (346 ширхэг толгойтой), Чингисийн өргөн чөлөөг Тээвэрчдийн гудамжтай холбосон авто зам, гүүрийн ажлын хүрээнд 2 толгойтой 49 гэрэлтүүлэг ашиглалтад орсон. 2. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 9, 10, 12 дугаар хороонд хэрэгжүүлсэн авто замын ажлын хүрээнд 2 толгойтой 80 ширхэг гэрэлтүүлэг, Зоос импекс ХХК-ийн 22 дугаар хороонд хэрэгжүүлсэн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 1 толгойтой 6 ширхэг гэрэлтүүлэг тус тус хийгдсэн. <p>Хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжиж ирсэнээр 2024 онд нийслэл, дүүргийн 1,245.7 сая</p>	

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>төгрөгийн хөрөнгөөр орон сууц хороолол, гэр хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 10804 шонгийн 12154 ширхэг гэрэлтүүлэгчийг мэргэжлийн 3 байгууллагад хариуцуулж, урсгал засвар, арчлалтыг тогтмол хийж, хяналт тавьж ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалтыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн төсвийн 720.0 сая төгрөгийн хөрөнгөөр ашиглалтын хугацаа дуусаж, техникийн шаардлага хангахгүй болсон 60 ширхэг алсын удирдлагын самбарыг бүрэн шинэчилж, ашиглалтад орууллаа.</p>	
		905.0 (ДТХО)	Засвар үйлчилгээг хариуцах гэрэлтүүлэг, тоо	6245 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.	10497 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.	<p>"Хан-Уул дүүргийн хэмжээнд 2024 онд гэрэлтүүлгийн урсгал засвар, арчлалтыг 3 бүсэд хувааж, нийт 10804 шонгийн 12154 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтыг мэргэжлийн 3 байгууллагад гэрээгээр хариуцуулж, хяналт тавьж ажиллаж байна. Гэрэлтүүлгийн урсгал, засвар арчлалтыг тогтмол графикайн дагуу гүйцэтгэж, засвар үйлчилгээний мэдээллийг Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төвд хүргэж ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт 98.5 хувьтай байна. Гэрэлтүүлгийн урсгал засварын гүйцэтгэлийг сар бүр хянаж, 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 997.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна."</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
Зорилт 13 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд эко бичил цэцэрлэгт хүрээлэнг бий болгож иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. (НЗДҮАХ 5.1.2.4, ДЗДҮАХ 1.1.1, 1.1.2, 2.1.5)							
17	Арга хэмжээ: 13.1 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд тохижилт, ногоон байгууламж бүхий, бичил цэцэрлэгт хүрээлэн тоглоомын талбай, спорт талбайг нэмэгдүүлж, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээний ажилд хотын стандартын хэм хэмжээ, шаардлагыг хангуулах арга хэмжээ авч ажиллана.	1,200.0 (УТХО) 2,300.0 (ДТХО)	Шинээр нэмэгдүүлсэн бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тоо	18 (2021-2023 он)	4 (Туул гол дагуу, Буянт Ухаа 2 хороолол, 25 жилийн ойн өндөрлөг, 41-р сургууль орчмын 4 байршилд бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулж, ашиглалтад оруулна.)	Бичил цэцэрлэгт хүрээлэн: Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 5, 24 дүгээр хороонд он дамжин хэрэгжиж буй 2, шинээр 1, 13, 14 дүгээр хороонд 3, дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороонд 1, нийт 6 бичил цэцэрлэгийн тохижилтын ажил хэрэгжүүлж хүртээмжийг нэмэгдүүлсэн бол 22 дугаар хорооны 1 байршилд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил он дамжин хэрэгжинэ. Үүнд: 1. Улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 5 дугаар хороонд 41 дүгээр сургуулийн баруун талд 700 м.кв авто зогсоол, 300 м.кв налууд эко хавтангийн хучилт, 130 м.кв талбайд явган хүний зам, 5x5 сагсан бөмбөгийн талбай, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажлууд бүрэн хэрэгжиж, ашиглалтад орсон. 2. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 24 дүгээр хорооны Вива сити хорооллын ард Туул гол дагуу тоглоомын талбай, спорт талбай бүхий тохижилтын ажил хэрэгжиж, ашиглалтад орсон. 3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран 1 дүгээр хорооны Эрэл хотхоны 38, 43-р байрны ард, 13 дугаар хорооны 4 дүгээр хэсэг, 14 дүгээр хорооны 156-р	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>бага сургууль, 300-р цэцэрлэгийн гадна 3 байршилд шинээр бичил цэцэрлэгийн тохижилтын ажил хэрэгжиж, ашиглалтад орсон.</p> <p>4. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороонд хэрэгжих цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд талбайн гэрэлтүүлэг, 1 талбайн теннис, хос 3х3 сагсан бөмбөгийн талбай, экстрем талбай шинээр байгуулж, 2 ширхэг 5х5 сагсан бөмбөгийн талбайг засварлаж, шинэчилсэн.</p> <p>Он дамжин хэрэгжих 1 төсөл арга хэмжээ:</p> <p>1.Хан-Уул дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул гол дагуу эрсдэлтэй бүсээс 28 айл өрхийг нүүлгэн шилжүүлж, чөлөөлөгдсөн 5 га талбайд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай 2023 онд санамж бичиг байгуулсаны дагуу цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Гарден сити" ХХК шалгарч гэрээ байгуулсан.</p>	
		1,135.0 (ДТХО)	Шинээр нэмэгдүүлсэн тоглоомын талбай, тохижилтын тоо	64 (2021-2023 он)	10-аас доошгүй	<p>Тоглоомын талбай:</p> <p>Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2,528.0 сая төгрөгийн хөрөнгөөр 1, 3, 12, 14, 15, 25 дугаар хорооны 7 байршилд тоглоомын талбай, тохижилтийн ажил хэрэгжиж дууссан. 15,19,21 дүгээр хорооны 5 байршилд 3 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжинэ.</p>	

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>Нэг. Хэрэгжиж дууссан</p> <ol style="list-style-type: none"> 1. 8, 18-р байрны гадна талбайн тохижилт, засвар шинэчлэлтийн ажил (1 дүгээр хороо) 2. 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, орчны тохижилтын ажил (12, 14 дүгээр хороо) 3. 41 дүгээр байрны гадна талбайн тохижилтын ажил (25 дугаар хороо) 4. Дэлгэрэх хотхон, Энхийг сахиулах 50 айлын тоглоомын талбайн засвар шинэчлэлтийн ажил (3 дугаар хороо, 2 байршил) 5. 218 дугаар цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилтын ажил (15 дугаар хороо) <p>Хоёр. Он дамжин хэрэгжих</p> <ol style="list-style-type: none"> 1. 130-р сургууль, 218-р цэцэрлэгийн гадна талбайн тохижилт 2. Буянт-Ухаа 2 хорооллын тоглоомын талбай (3 байршил) 3. 19 дүгээр хороолол 70А байрны баруун талын тохижилтын ажил 	
		1,722.8 (ДТХО) 250.0 (ДОНХС)	Ашиглалтад оруулсан спорт талбайн тоо	22 (2021-2023 он)	9 спорт талбай шинээр байгуулж, 1 спорт заалыг засварлана.	<p>Хан-Уул дүүрэгт 2024 онд нийслэл, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 3x3 сагсан бөмбөгийн 20 талбай, 3 байршилд спорт талбайн тохижилтын ажлыг ашиглалтад оруулж спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүллээ. Үүнд:</p> <p>Он дамжи хэрэгжсэн:</p> <p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. 8 дугаар хороо, 118 дугаар сургууль, 	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>2. 12 дугаар хороо, Сонгино 25 дугаар гудамж, 3. 24 дүгээр хороо, Ханбогд хотхоны 201-р байрны гадна 3 байршилд он дамжин хэрэгжсэн 3х3 сагсан бөмбөгийн талбай ашиглалтад орсон. Энэ онд шинээр хэрэгжсэн: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 8, 12, 14, 17, 24, 25 дугаар хороонд 9 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж бүхий тохижилтын ажил, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд 5х5 сагсан бөмбөгийн талбай, талбайн теннис, чийрэгжүүлэлтийн талбай бүхий спорт талбайг тус тус ашиглалтад оруулсан Дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4, 12, 14, 15, 20, 24, 25 дугаар хороонд 3х3 сагсан бөмбөгийн 8 талбай байгуулах, дүүргийн төсвийн хөрөнгөөр 15 дугаар хороонд 130 дугаар сургуулийн гадна газар чөлөөлж спорт талбай байгуулах, 7, 89 дүгээр сургуулийн гадна спорт талбайн засвар, шинэчлэлт хийх ажил тус тус хэрэгжиж дууссан.</p>	
		979.1 (ДТХО)	Засварлаж, шинэчилсэн талбай, эд хөрөнгийн тоо	4 байршилд цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, 1 хөшөөг	4-ээс доошгүй байршилд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг засварлаж,	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 2024 онд дүүргийн төсвийн 3,393.7 сая төгрөгийн хөрөнгөөр тохижилт, шинэчлэлтийн чиглэлээр 8 төсөл арга хэмжээ	

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
				засварлаж шинэчилсэн.	орчны аюулгүй байдлыг хангуулна.	<p>хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 4 төсөл арга хэмжээ 2023-2024 онд он дамжин хэрэгжих, 4 төсөл арга хэмжээ 2024 онд шинээр хэрэгжиж дууссан байна.</p> <p>Үүнд:</p> <p>Дүүргийн төсвөөр 2024 онд шинээр хэрэгжих (935.0 сая төгрөг):</p> <ol style="list-style-type: none"> 209 дүгээр цэцэрлэгийн гадна тохижилтын ажил (8 дугаар хороо) 65-р байрны тохижилт гадна талбайн тохижилтын ажил (15 дугаар хороо) 7, 89 дугаар сургуулийн спорт талбайн засвар шинэчлэлт (16 дугаар хороо) Дэлгэрэх хотхон, Энхийг сахиулах 50 айлын тоглоомын талбайн засвар шинэчлэлтийн ажил (3 дугаар хороо) <p>Дүүргийн төсвөөр 2023-2024 он дамжин хэрэгжиж дууссан (2,458.7 сая төгрөг):</p> <ol style="list-style-type: none"> Наран хотхон, 8, 18-р байрны гадна талбайн тохижилт, засвар шинэчлэлтийн ажил (1 дүгээр хороо) Ажилчны алдар талбайн тохижилт (2 дугаар хороо) Гадна талбайн тохижилтын ажил (10-р хороо 60/2 дугаар байр, 13-р хороо 144-р цэцэрлэг, 14-р хороо 59-р сургууль) Сагсан бөмбөгийн 3x3 талбай байгуулах (Нисэх яармагийн бүс) <p>Засвар:</p> <p>Хүүхдийн тоглоомын талбайн стандарт, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 10, 13, 14,</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						17, 19 дүгээр хорооны 21 байршилд тоглоомын талбайг засварлах судалгаа, ажлын тоо хэмжээг гаргаж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/203 дугаар захирамжаар Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулж, хяналт тавьж ажиллаж, хэрэгжүүлж дууссан. Эвдрэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, тоглоомын талбай, явган хүний зам талбайн судалгаа, тооцооллыг боловсруулж, дүүргийн Засаг даргын 17 захирамжаар 1,184.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд стандарт орчны аюулгүй байдлыг хангаж, засварлаж, шинэчлэх чиглэлээр 117 арга хэмжээг хэрэгжүүлсэн.	
18	Арга хэмжээ: 13.2 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудыг идэвхжүүлэх, татан оролцуулах болзолт аян, уралдааныг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	“Манай хороо – Миний гудамж” аяныг зохион байгуулсан.	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотой тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 1 аян зохион байгуулна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/67 дугаар захирамжийг батлуулж, хороод, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн 190 аж ахуйн нэгжид гадна тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах, гэрэлтүүлэг, хаягийн байгууламжийг сайжруулах талаар үүрэг чиглэл өгч, хаягийн байгууламжийг шинэчлэх шаардлагатай 5 аж ахуйн нэгжийн хаягийн байгууламжийг стандартад	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						нийцүүлэн солиулж, 3 аж ахуйн нэгж, гадна талбайг бүрэн тохижуулсан. Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аяныг зохион байгуулж, хавар 1650 өрх, 104 сууц өмчлөгчдийн холбоо, 23 цэцэрлэг, 16 ерөнхий боловсролын сургууль, аж ахуйн нэгж байгууллагууд нэгдэж, 206419 ширхэг мод, бут сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.	
Зорилт 14 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. (ЗГҮАХ 6.1.8, НЗДҮАХ 5.1.1.5, ДЗДҮАХ 1.1.1, 1.1.2, 1.1.3, 5.3.5)							
19	Арга хэмжээ: 14.1 Дүүргийн хэмжээнд нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж арчилж хамгаалах, мэдээллийн сан үүсгэх болон мод тарьж ургуулах, арчлах хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр онол, практикт суурилсан сургалт нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулна.	1,037.9 (ДТХО)	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аяныг 2, 3 удаагийн сургалт, 10 цахим сурталчилгаа, 1050 гарын авлагыг бэлтгэж, түгээсэн.	Мод тарих 2 удаагийн аян, сургалт, сурталчилгааны 10-аас багагүй арга хэмжээг зохион байгуулна.	"Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяныг хавар, намар 2 удаа зохион байгуулж, нийт 206419 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Тухайлбал: 1. Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр гэр хорооллын бүсэд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1650 хашаанд гоёлын болон жимсний 7 төрлийн 16,575, 104 СӨХ, 11 сургууль, цэцэрлэг, 10 хорооны гадна нийт 125 байршилд гоёл чимэглэлийн 7767, аж ахуйн нэгж, байгууллагууд орчиндоо 16,872, нийт 41214 ширхэг мод, бут сөөг, тарьсан. 2. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд арчилгаа, нөхөн тарилт хариуцсан 10 байгууллага 19289 ширхэг мод, бут сөөг тарьсан. 3. Тусгай хэрэгцээний ногоон	90%
			Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ, м.кв	9.32 (2023 оны жилийн эцсийн байдлаар)	9.5 (Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 0.2 м.кв талбайгаар нэмэгдүүлнэ)		

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн 14 дүгээр хорооны Айцын аманд нийслэл, дүүргийн 38 хэлтэс албадын 645 албан хаагч 2022-2024 онд байгуулсан 12.3 га талбайд усалгаа, арчилгаа хийж, нэмэлтээр болон нөхөн тарилтаар 3196, Ногоон хэрэм төслийн талбайд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын харьяа агентлагууд, төрийн захиргааны төв байгууллагууд 9175, Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний ам, Зайсангийн ам, Нүхтийн ам, Энхтайвны ам, Ихтэнгэрийн аманд 136 га талбайд уул уурхайн 5 компани, улсын хөрөнгө оруулалтаар 1 компани ойжуулалтын ажил хийж, 133545 ширхэг, нийт 145916 ширхэг мод, бут, сөөг тарьсан байна.</p>	
		124.0 (ДТХО)	Ногоон байгууламжийн судалгаа, мэдээллийн сан хийх ажлын явц	10% (2021 онд загвар мэдээллийн санг үүсгэсэн)	100% (Газарзүй, мэдээллийн системд суурилсан мэдээллийн санг бий болгож, ашиглалтад оруулна.)	<p>Ногоон байгууламжийн судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх зөвлөх үйлчилгээ хийх ажлын даалгаврыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газартай зөвшилцөн боловсруулж, 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр батлуулж, худалдан авах ажиллагаанд шилжүүлсэн. Ногоон байгууламжийн судалгаа, мэдээллийн сан хийх ажлын гүйцэтгэгчээр "Говийн улиас" ХХК шалгарч, ажлын бэлтгэл үе, хээрийн судалгааны шат хэрэгжин дуусч, агаарын зургийг ашиглан ногоон байгууламжийн хил, заагийг дахин</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						засварлаж, зураглах, ногоон байгууламжийн нэгж талбар тус бүрээр мэдээллийн сан үүсгэх шатанд хэрэгжиж байна.	
		2,049.2 (ДТХО)	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг арчилж, хамгаалах талбайн хэмжээ, м.кв	-	289,376	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/97 дугаар захирамжаар Айцын ам, Төгсөгчдийн төглийн 13.5 га талбайн арчилгааг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулан гэрээ байгуулж, хяналт тавьж ажилласан. Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аяны хүрээнд нийслэл, дүүргийн төр захиргааны 68 хэлтэс албадын 796 албан хаагчид 2022-2024 онд тарьсан модны усалгаа арчилгааг хийж, шинээр болон нөхөн тарилтаар 3196 мод тарьсан. Намрын мод тарилтын ажлын хүрээнд Төгсөгчдийн төгөлд шинээр 178 улиас тарьж, усалгаа арчилгааг хийсэн.	
20	Арга хэмжээ: 14.2 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд цэцгийн мандал байгуулах, сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлж тоосжилтыг бууруулна.	150.0 (ДТХО)	Цэцгийн мандал байгуулсан талбай, м.кв	2023 онд 5379,3 м.кв талбайд цэцгийн мандал байгуулсан.	3000 м.кв-аас багагүй талбайд цэцгийн мандал байгуулж, усалгаа, арчлалт хамгаалалтыг сайжруулна.	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цэцэг тарих ажлын төлөвлөгөө, байршлын судалгаа, төсвийн тооцооллыг боловсруулж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/78 дугаар захирамжаар 191.4 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн. “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-аар 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 30 хүртэл 300,000 гаруй ширхэг нэг наст, гоёл чимэглэлийн цэцгийн	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						үрсэлгээг хийлгэж, талбайн бэлтгэл ажлыг бүрэн хангуулсан.	
			Зүлэгжүүлсэн талбай, м.кв	2023 онд 24192.8 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлсэн.	15,000 м.кв-аас багагүй талбайг зүлэгжүүлнэ.	Батлагдсан төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилт хариуцсан 10 байгууллагаар нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 48 байршилд 478,730 гаруй цэцэг тариулж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгүүлж, хяналт тавьж ажилласан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд цэцэгт байгууламж хийх байршлын судалгаа, саналыг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлж, 2024 оны 06, 07 дугаар сард 8 байршилд 3 хэмжээст хийцлэл бүхий цэцэгт байгууламж хийж, 154,250 ширхэг цэцэг, 300 м.кв зүлэг тарих ажлыг зохион байгуулж, хамтарч ажилласан.	
Зорилт 15 Дүүргийн гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлнэ. (ДЗДҮАХ 5.1.4)							
21	Арга хэмжээ: 15.1 Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	91.1% (5 бүлгийн 89 арга хэмжээг төлөвлөж 91.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.)	2-оос доошгүй удаагийн арга хэмжээг зохион байгуулна.	"Тохижилт бүтээн байгуулалтын жил болгон зарласантай холбогдуулан хотын стандартыг хэрэгжүүлэх, төлөвлөгөөнд тусгах санал солилцох уулзалтыг 2024 оны 01 дүгээр сарын 26-нд зохион байгуулж, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Техник хяналтын алба байгуулж, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, орон нутгийн бусад эх үүсвэрээс	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>санхүүжин хэрэгжиж буй тохижилт, бүтээн байгуулалтын 95 төсөл арга хэмжээний төлөвлөлт, ажлын явц, гүйцэтгэлд холбогдох стандарт, норм дүрмийг мөрдүүлэн хяналт тавьсан.</p> <p>2. Хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжсэнээр гэрэлтүүлгийн урсгал, засвар ашиглалт хариуцсан 3, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг хариуцсан 10, зам талбайн цэвэрлэгээ хариуцсан 13, энгийн хог хаягдлын тээвэрлэлт хариуцсан 4 байгууллагын ажил, үйлчилгээнд холбогдох стандарт, норм дүрмийг мөрдүүлж, хяналт тавьж байна.</p> <p>3. Хотын стандарт, хяналтын газрын Байгаль орчны стандартын хэлтэстэй хамтарч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлын менежмент, ногоон байгууламжийн бүлгийн стандартыг танилцуулах сургалтыг 3 удаа зохион байгуулж, сууц өмчлөгчдийн 75 холбоо, ногоон байгууламжийн арчилгааны 10 компани, зам талбайн цэвэрлэгээ, хог тээвэр хариуцсан 12 байгууллагын 500 ажилтан, албан хаагчдыг хамруулсан.</p> <p>4. Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системд бүртгэгдсэн нийтийн эзэмшлийн гудамж талбайд хамаарах 35 зөрчлийг бүрэн шийдвэрлэсэн.</p> <p>5. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд стандарт орчны аюулгүй</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>байдлыг хангах ажлын хүрээнд Тохижилтын ажлын засвар, шинэчлэлтийн зардлаас 1,184.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж, тоглоомын талбай, явган хүний зам талбайг, хөшөө дурсгалыг засварлах, орон сууц хороолол, гэр хорооллын гудамж талбайд зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хайс хашлага засварлах чиглэлээр 17 захирамжийн хүрээнд 117 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <p>6. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/149 дүгээр захирамжийн хүрээнд стандарт хангаагүй 189 аж ахуй нэгж байгууллага, иргэнд мэдэгдэх хуудас хүргүүлж, 31 ширхэг мэдээллийн тулгуурт самбар, 42 ширхэг А самбар, хайс, хашлага дээр байрлуулсан 76 ширхэг хулдаасан сурталчилгааны самбар буулган, 110 газарт зөвлөмж хүргүүлж гадна хаягжилтыг сайжруулах шаардлагатай 39 газарт тухайн үйлчилгээндээ таарсан хаягийн байгууламжийг хийх хугацаатай үүрэг даалгавар өгч, хяналт тавьсан.</p>	
22	Арга хэмжээ: 15.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлж ажиллана.	-	Захиалагчийн хяналт тавьсан төсөл арга хэмжээ, тоо	86 төсөл арга хэмжээний явц, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, стандарт, норм, дүрмийг мөрдүүлж ажилласан.	50-иас доошгүй төсөл арга хэмжээний явц, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, стандарт, норм, дүрмийг	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/13 дугаар захирамжаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдэд хяналт тавих, байнгын ашиглалтад оруулах захиалагчийн хяналтын албыг байгуулан ажиллаж байна.	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
					мөрдүүлж ажиллана.	Тус алба нь 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 95 төсөл арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.	
Зорилт 16 Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана. (ЗГҮАХ 4.3.2, ДЗДҮАХ 3.4.2)							
23	Арга хэмжээ: 16.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайн теле хяналтын камерын тоог нэмэгдүүлж, засвар, үйлчилгээг сайжруулж, ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.	1,273.9 (ДОНХС)	Ажлын явц, хувь	Камержуулалтын 5 төсөл арга хэмжээний ажлын явц 10-90 хувь	100	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 2024 онд шинээр нийт 715 камер суурилуулахаар төлөвлөгдсөнөөс 2024 оны байдлаар 4 төсөл арга хэмжээ туршилт, тохируулгын шатанд, 2 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд 10-15 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Камер суурилуулж туршилт, тохируулга хийгдэж буй 4 төсөл, арга хэмжээ: 1. "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 1, 2, 3, 6, 7, 8, 17-р хороо" - 53 ширхэг камер, 2. "Камержуулалт 1-5, 9-11, 13-21-р хороо" - 117 ширхэг камер, 3. "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт" төсөл арга хэмжээний хүрээнд 12, 13, 14, 16, 21-р хороодод тусгай зориулалтын 10 ширхэг камер, 4. "Камерын хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар хийх" төсөл, арга хэмжээний хүрээнд серверийн өрөөний тоноглол суурилуулалтын ажил. Хэрэгжих шатанд 2 төсөл, арга хэмжээ:	100%
		-	Шинээр суурилуулж, ашиглалт оруулсан камерын тоо	Дүүргийн хэмжээнд 320 цэгт камер сууриулагдсан. /2021-2023 он/	200-аас доошгүй		

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>1. "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 4-10, 12, 13, 14, 16, 21-р хороо" - 80 ширхэг камер</p> <p>2. Камержуулалтын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажил /9, 10, 16, 21-р хороо/ - 314 ширхэг камер суурилуулах ажил</p> <p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамжийн ажил"-ын гүйцэтгэгчээр "Бодь электроникс" ХХК шалгарсан бөгөөд дотор засал, тоног төхөөрөмж суурилуулах ажил бүрэн дуусч, гадна цахилгааны 2 дахь эх үүсвэрт холбох ажил хэрэгжиж байна. Тус ажлын хүрээнд дүүргийн өвөлжилтийн бэлтгэл хангах зардлаас санхүүжилтийг шийдвэрлэж, хяналтын төвийн цонх, цахилгаан, цэвэр усны насосыг засварласан.</p>	
		1,000.0 (ДТХО)	Засвар үйлчилгээг хариуцах камер, тоо	1230 ширхэг камерын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.	1230 ширхэг камерын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.	<p>"Нийтлэг үйлчилгээний алба" ОНӨААТҮГ-т төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 1232 ширхэг хяналтын камерын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцуулсан бөгөөд 2024 онд Иргэдэд үйлчлэх төв байр, хороодын байр болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд 82 хяналтын камерыг засварлаж, 75 хяналтын камерыг шинээр суурилуулсан.</p>	
Зорилт 17 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (НЗДҮАХ 5.1.1.6, ДЗДҮАХ 5.4.1)							

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
24	Арга хэмжээ: 17.1 Хог хаягдлыг бууруулах, тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний менежментийг сайжруулах, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлоос байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	8,200.0 (ДТХО)	Шинээр нэмэгдүүлсэн хог тээвэр, зам талбайн машин, техник хэрэгслийн тоо	Хог тээврийн 32 машин, зам цэвэрлэгээ, усалгааны 3 машинаар парк шинэчлэлт хийсэн. (2021-2023 он)	10-аас доошгүй хог тээврийн авто машин, 6-аас доошгүй зам зам цэвэрлэгээ арчилгаанд шаардлагатай автомашин, механизмаар парк шинэчлэлт хийнэ.	Хог тээвэр, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд дүүрэг, нийслэлийн төсвийн хөрөнгөөр нэмэлт тоноглол бүхий /цас хусах, давс бодис цацах/ 21 хог тээврийн авто машин, 9 зам талбай цэвэрлэгээ үйлчилгээний машин, олон үйлдэлт бага оврын ачигч авто машин техникийн худалдан авалт хийгдсэн. Төсөл арга хэмжээ тус бүрээр авч үзвэл: -Дүүргийн төсвийн хөрөнгөөр /он дамжин хэрэгжсэн/ ХСМГ маркийн задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 7 ширхэг хогны автомашины худалдан авалт хийгдэж 2024 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хог тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн. -Дүүргийн төсвийн хөрөнгөөр задгай тэвштэй, 8 тн даацтай, цас хусагчтай 9 ширхэг хогны автомашины худалдан авалт хийгдэж, 2024 оны 07 дугаар сарын 27-ны өдөр хог тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн. -Дүүргийн төсвийн хөрөнгөөр хог хаягдлыг шахаж ачих зориулалттай 4 машины худалдан авалт хийгдэж 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүлээлгэн өгсөн. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 8 тн багтаамжтай, хог хаягдал шахаж ачих зориулалттай 1 машин, зам талбай цэвэрлэх, цас мөс хусах тусгай зориулалтын машин,	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						олон үйлдэлт бага оврын ачигч 9, нийт 10 авто машин, техникийг хүлээлгэн өгсөн.	
		3,384.8 (ДТХО)	Цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах зам, талбайн хэмжээ, м.кв	1,043,793	3,507,887 (төв зам, орон сууц, гэр хорооллын авто зам, явган хүний замын хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж, халтиргаа, гулгаанаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана)	Зам талбайн цэвэрлэгээний техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр зам цэвэрлэх, услах, шүүрдэх, ариутгах хосолмол үйлдэлтэй том 2 машин, үлээгч төхөөрөмж 50 ширхэг, цахилгаан мотортой шүүрдэгч 27 ширхэг, бага оврын давс цацагч 15 ширхэг, замын нуух шүүрдэгч бага оврын 7 машиныг худалдаж авсан. Тус ажлын хүрээнд 4 үйлдэлт ковш 12, экскаватор 1, зам талбайн ажилчдын автобус 4, автокран 3, зам усалгаа, ариутгалын машин 3, нийт 23 машин механизм нийлүүлэгдэх шатандаа байна. Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Чиг үүрэг шилжүүлэх тухай” 2023 оны А/1461 дүгээр захирамжаар хот, нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжиж ирсэнээр нийт 4,225,209 м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээг 13 байгууллагад хариуцуулан, ажлын явц, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/162 дугаар захирамжийн дагуу “Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон” ТББ-тай гэрээ байгуулан дүүргийн нийтийн эзэмшлийн нийт зам талбайн	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						цэвэрлэгээ, үйлчилгээнд хөндлөнгийн хяналтыг гүйцэтгүүлж байна. Зам талбайн байгууллагуудад 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 11,588.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд 11, 12 дугаар сарын гүйцэтгэлийн 12 дугаар сарын 05, 11-ний өдрийн дотор хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	
		50.0 (ДТХО)	Зохион байгуулах их цэвэрлэгээ, тоо	Бүх нийтийн их цэвэрлэгээг 12 удаа зохион байгуулж, 451.8 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.	Бүх нийтийн их цэвэрлэгээг 10- аас доошгүй удаа зохион байгуулж, хог хаягдлыг бууруулна.	Дүүргийн Засаг даргын 2024 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан "Хоггүй Хан-Уул 2024" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 11 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 5894 аж ахуй нэгж байгууллага, 336 сууц өмчлөгчдийн холбоодын 6,916 хүн оролцож, 5,721,809 м.кв талбайгаас 1053,3 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн. Батлагдсан хуваарийн дагуу 2024 оны 12 дугаар сард нэгдсэн бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна.	
		378.3 (ДТХО)	Ариутгаж халдваргүйжүү лэх ажлын тоо хэмжээ	Бохирдол ихтэй 380,700 м.кв талбай, 17831 ширхэг нүхэн жорлон, бохирын цооног	300,000 м.кв- аас багагүй талбай, 17,000- аас багагүй нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүү лнэ.	Дүүргийн хэмжээнд нийт 25 хороодын 78 байршлын 357,000 м.кв талбай, 11086 нүхэн жорлон, 5914 бохирын цооног ариутгаж, халдваргүйжүүлсэн. Үүнд: - Дүүргийн Засаг даргын А/155 дугаар захирамжийн дагуу хороодоос ирүүлсэн байршлын дагуу нийтийн эзэмшлийн бохирдол ихтэй болон	

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>шар усны үер урссан 40,000 м.кв талбайг мэргэжлийн байгууллагаар ариутгуулан хяналт тавьж ажилласан.</p> <p>- Дүүргийн Засаг даргын 2024 оны А/125 дугаар захирамжийн дагуу 8, 10, 12, 13, 14, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт үхсэн мал амьтны сэг зэм, өтөг бууцыг цэвэрлэж, нийт 23,000 м.кв талбайг ариутгаж, 5258.14 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.</p> <p>- Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас дүүргийн хэмжээнд бохирдол ихтэй 200,000 м.кв талбайд мананцарт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.</p> <p>- Дүүргийн Засаг даргын 2024 оны А/297 дугаар захирамжийн дагуу гэр хорооллын 11086 нүхэн жорлон, 5914 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлсэн.</p> <p>- Дүүргийн Засаг даргын 2024 оны А/600 дугаар захирамжийн дагуу нийслэл, дүүргийн 2024 оны ээлжит сонгуулийн 29 дүгээрт тойргийн 73 санал авах байрыг 2 удаагийн давтамжтай ариутгаж, халдваргүйжүүлсэн."</p>	
<p>Зорилт 18 Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ 5.1.6)</p>							

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
25	Арга хэмжээ: 18.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	100.0 (ДТХО)	Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо, хэрэгжилтийн хувь	38 аж ахуй нэгжид холбогдох ус, газар, байгалийн нөөцийг хуулийн дагуу ашиглаж, нөхөн сэргээж, нөөц ашигласны төлбөрөө хугацаанд нь төлж байгаа эсэхэд 5 удаагийн хяналт шалгалт хийсэн.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд 5-аас доошгүй удаагийн хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын 2023 оны А/151 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүрэгт түгээмэл тархалттай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг 11 аж ахуйн нэгжийн 123 тээврийн хэрэгсэлтэй, Төв аймгийн Алтанбулаг суманд үйл ажиллагаа эрхэлдэг 10 аж ахуйн нэгжийн 213 тээврийн хэрэгсэлтэй “Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ”-г хийж, хяналт тавьж байна. Таван толгойн хяналтын постод 24 цагаар 3 ээлжинд давхардсан тоогоор 30 алба хаагч үүрэг гүйцэтгэж Улаанбаатар хот орох чиглэлд түгээмэл тархацтай ашигт малтмал тээвэрлэж явсан 20200 тээврийн хэрэгслийг бүртгэж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, Зөрчлийн тухай хууль зөрчсөн 1987 тээврийн хэрэгслэлийн жолоочийг 117,203,500 төгрөгөөр торгож шийтгэл оногдуулсан.	100%
			Нөхөн сэргээлт хийсэн талбай, га	13.6 га газарт техникийн нөхөн сэргээлт, 5,4 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудт ай хамтарч уул уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн 10-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийнэ.	Нийслэлийн байгаль орчны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/161 дүгээр тушаалын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсэг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Хан-Уул дүүрэгт	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						ажиллалаа. Тус хяналт шалгалтаар түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 10 байгууллага нөхөн сэргээлт хүлээлгэж өгсөн. Үүнээс 5 байгууллага дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр 12 дугаар хороонд булгийн эх хашиж, тохижуулах, 5 байгууллага 4.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 0.5 га талбайд биологийн нөхөн сэргээлтээр мод тарьж, хүлээлгэж өгсөн. Мянганы сорилтын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Баруун бүсийн усны эх үүсвэр" төслийн хүрээнд 3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж, 1 га талбайд 1500 мод тарьж ургуулсан.	
Зорилт 19 Дүүргийн Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, эмч, сувилагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг чанартай хүргэх зорилгоор “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 2.2.8/							
26	Арга хэмжээ: 19.1 “Эрүүл дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.		Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь хэрэгжүүлсэн.	90-ээс дээш хувь хэрэгжүүлнэ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 245.0 сая төгрөг баталсан. Тус дэд хөтөлбөрийн 5 зорилт, 28 арга хэмжээний хүрээнд 15 төсөл, арга хэмжээг 192,3 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Дэмжигдсэн хөтөлбөрүүд: 1 дүгээр зорилтын хүрээнд “12, 14 дүгээр хорооны хүүхэд багачуудын амны хөндийн эрүүл ахуйн үзлэг, оношилгоо арга хэмжээ” төслийг дэмжиж амны хөндийн эрүүл ахуйн	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>боловсрол олгож, үзлэгт хамруулан өвчлөлөөс урьдчилан сэргийлсэн.</p> <p>“Таван төрөлт тэмцээнд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх”, “Параволейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх төсөл” “Иргэдийн спортын XII их наадмын И-спортын төрлийг зохион байгуулах” төслийг тус тус хэрэгжүүлж нийтийн биеийн тамир, спортын олон талт арга хэмжээг дэмжиж, нийгмийн эрүүл мэндийг сайжруулсан.</p> <p>3 дугаар зорилтын хүрээнд “16 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвд шүдний эмчилгээний тоног төхөөрөмж”, “18 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд эмэгтэйчүүдийн өрөөний тоног төхөөрөмж”, “Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, харилцан суралцах” төслийг тус тус хэрэгжүүлж эрүүл мэндийн байгууллагуудын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулсан.</p> <p>5 дугаар зорилтын хүрээнд “Эрүүл ажилтан өндөр бүтээмж” төсөл хэрэгжүүлж эмнэлгийн ажилчдыг хэвийн ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, Япон, БНСУ, Тайвань, Сингапур, Турк улсуудад эмч, эмнэлгийн ажилтнуудыг сайн туршлага судлуулан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангасан.</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
Зорилт 20 Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багш нарыг урамшуулах, дэмжих, тэдний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Багш” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.1.2/							
27	Арга хэмжээ: 20.1 Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээг шалгаруулан хэрэгжүүлнэ. /Багш нарын баяр, Багш, ажилчдын биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, туршлага судлах сургалт, зөвлөгөөн... гэх мэт/	150.0	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь хэрэгжүүлсэн.	90-ээс дээш хувь хэрэгжүүлнэ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар "Багш" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 175.0 сая төгрөг баталсан. Тус дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 5 төсөл арга хэмжээ, 2 дугаар зорилтын хүрээнд 1 төсөл, 3 дугаар зорилтын хүрээнд 3, нийт 9 төсөл арга хэмжээг 664,086,712 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Үүнд: -Япон, БНСУ, БНХАУ-д туршлага судлах, ур чадварыг дээшлүүлэх, сургалтад оролцуулахын зэрэгцээ гадна "Өвийн сургагч багш бэлтгэх" төсөл хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн багш нарын заах арга ур чадварыг нэмэгдүүлэх “Ур чадвар”-ын уралдаан, төрийн өмчийн сургуулиудын багш ажилчдын дундах 5 төрөлт тэмцээн зохион байгуулж 23 сургууль, 38 цэцэрлэгийн 3,015 багшийг хамруулсан. -Ерөнхий боловсролын 18 дугаар сургуулийн Биологийн кабинет байгуулах төслийг хэрэгжүүлсэн. -УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлангийн санаачилгаар багш бүрийг компьютерээр хангах ажлын хүрээнд 23 сургуульд 640, 40 цэцэрлэгт 192, Насан туршийн суралцахуйн төвд 4, боловсролын хэлтэст 2, Залуу багш нарын ур чадварын уралдаанд шалгарсан 3 багшид 2,360.2 сая төгрөгийн 841	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>зөөврийн компьютерийг хүлээлгэн өгсөн.</p> <p>-БНСУ-ын Сөүл хоттой боловсролын хамтын ажиллагааны хүрээнд Нийслэлийн Боловсролын газраас 10, 163 дугаар сургуульд 20 зөөврийн компьютер, 15 компьютер олгосон.</p> <p>-Цахим техник хангамжийг сайжруулах зорилгоор ерөнхий боловсролын 23 сургууль улсын төсвийн 116.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Notebook-21, Tablet-52, PC-24 ширхэгийг авсан. Тус хөтөлбөрийн хүрээнд багш, удирдах ажилтнуудын ажиллах урам зориг, шинийг эрэлхийлэх санал санаачилга нэмэгдэж, заах арга зүй, ур чадвар сайжирч, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэн, тэдний бүхий л үйл ажиллагааг дэмжсэн сайн технологиудыг түгээн дэлгэрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.</p>	
<p>Зорилт 21 Ахмадуудын хөгжлийг дэмжих, тэдний мэдлэг туршлагаа залуу үедээ хуваалцах боломжийг хангах үүднээс “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.2.4/</p>							
28	<p>Арга хэмжээ: 21.1</p> <p>Ахмадуудын аж байдал, нийгмийн хамгааллыг сайжруулах эрүүл насжих, олон нийт гэр бүлийн дунд тэгш эрхтэй сэтгэл хангалуун амьдрах ээлтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. /Цагаан сар, ахмадын баярыг тохиолдуулан ахмад настуудад хүндэтгэл</p>	350.0	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь хэрэгжүүлсэн.	90-ээс дээш хувь хэрэгжүүлнэ.	<p>Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар "Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 390.0 сая төгрөг баталсан. Тус дэд хөтөлбөрийн 3 зорилт, 5 арга хэмжээний хүрээнд 6 төсөл, арга хэмжээг 366.4 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>1 дүгээр зорилтын хүрээнд Хөдөлмөрийн баатруудын замнал арга хэмжээнд 30 хөдөлмөрийн баатар ахмад настанг,</p>	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	үзүүлэх арга хэмжээ, Хаврын аяз гэх мэт/					2 дугаар зорилтын хүрээнд 19 дүгээр хорооны Ахмадын хөгжлийн төвийг тохижуулахад шаардлагатай эд хэрэгсэл нийлүүлэх төсөл, 16 дугаар хорооны ахмад настуудыг эрдсийн шинжилгээнд хамруулах арга хэмжээнд 300 ахмадыг, 3 дугаар зорилтын хүрээнд "Сар шинийн баяр", "Ахмадын баяр" төслүүдийг хэрэгжүүлж 13,000 ахмад настанг хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд хамруулсан. Дүүргийн засаг даргын 8 удаагийн захирамжаар зорилтот бүлгийн 16 ахмад настанд гэр олгосон.	
Зорилт 22 "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн авьяас хөгжүүлэх сургалт, дугуйланг нэмэгдүүлж, хүүхэд залуучуудын чөлөөт цагт зориулсан танхим нээж соёлын үйлчилгээ үзүүлнэ. /ДЗДҮАХ 4.5.2/							
29	Арга хэмжээ: 22.1 Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд сурч хөгжих таатай орчин бий болгох, үндэсний хэл соёл, уламжлалаа эрхэмлэдэг иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлнэ. /Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийн урлагийн их наадам гэх мэт/.	-	-	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь хэрэгжүүлсэн.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд 2024 онд хэрэгжүүлэхэд 810.0 сая төгрөг баталсан. Тус дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 21, 2 дугаар зорилтын хүрээнд 17, 3 дугаар зорилтын хүрээнд 7, нийт 45 төсөл, арга хэмжээг 664,086,712 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Үүнд: 1 дүгээр зорилтын хүрээнд ерөнхий боловсролын 26, 59, 163 дугаар сургуульд бага ангийн танхим тохижуулах, гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл нийлүүлэх, 41, 121, 134, 165, 190, 223, 250, 290, 312, 313, 322, 326, 335, 336, 342 дугаар цэцэрлэгүүдийн гал тогоо, зөөлөн эдлэл, хивс хивсэнцэр	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>нийлүүлэх болон сургалтын танхимуудыг тохижуулах төслүүдийг хэрэгжүүлснээр хүүхдүүдийн сурч хөгжих таатай орчин, мэдлэг чадварыг дээшлүүлэх, хоол үйлдвэрлэл үйлчилгээ болон эрүүл ахуйн материаллаг орчныг бүрдүүлсэн.</p> <p>2 дугаар зорилтын хүрээнд Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн уралдаанд эх орноо төлөөлөн оролцох болсон дүүргийн өсвөрийн шигшээ багийн 40 тамирчинд 80,9 сая төгрөгийн замын зардлын дэмжлэгийг үзүүлснээр биеийн тамир спортоор хичээллэх залуучуудын тоо нэмэгдэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, хувийн амжилтаа ахиулах, бусдаас суралцах, эх орноо олон улсад таниулах нөхцлийг бүрдүүлсэн.</p> <p>3 дугаар зорилтын хүрээнд "Мэргэжил бүхэн сайхан", "Хүүхдийн баярын бэлэг", "Хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээ", 89 дүгээр сургуулийн волейболын дугуйлангийн сурагч, багш нарт дэмжлэг үзүүлэх төсөл, "Хичээлийн хоцрогдол арилгах", "Зорилтот өрхийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл олгох", 250 дугаар цэцэрлэгийн гимнастикч хүүхдүүд болон багш нарын биеийн тамирын хувцас, хэрэглэгдэхүүн олгох төслүүдийг хэрэгжүүлэн зөв дадал, хэвшилтэй, үндэсний бахархалтай иргэн болон төлөвших, боловсролын</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, хүүхэд бүр сурч боловсрох тэгш боломжоор хангагдах нөхцөлийг бүрдүүлсэн.	
30	Арга хэмжээ: 22.2 Байгалийн ухааны хичээлийн /математик, хими, физик/ уралдааныг зохион байгуулна.	80.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 удаагийн арга хэмжээнд 9000 сурагчийг хамруулсан.	1 удаа 4500-аас доошгүй сурагчийг хамруулна.	Нийслэлийн Боловсролын газрын даргын удирдамжийн дагуу 2024-2025 оны хичээлийн жилд төрөлжсөн олимпиадын 1 дүгээр шатыг ерөнхий боловсролын сургуулиудад 2024 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд 13 төрлөөр зохион байгуулсан. Тус төрөлжсөн олимпиадыг ерөнхий боловсролын 58 сургуулийн давхардсан тоогоор 37,721 сурагч, 3 төрөлд ерөнхий боловсролын 48 сургуулийн 241 багш оролцож дүүргийн хэмжээний шилдгүүдээ тодруулж дурсгалын зүйлийг гардуулах ажлыг зохион байгуулсан. Шилдгээр шалгарсан багш, сурагчдын 2 дугаар шатны төрөлжсөн олимпиадыг 2024 оны 12 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд зохион байгуулах бэлтгэлээ ажлыг хангаж байна.	100%
Зорилт 23 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.5.4/							
31	Арга хэмжээ: 23.1 Залуучуудад дүүргийн хөгжил, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцох, хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэн, гэр бүлийн болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлж, эх оронч үзлийг төлөвшүүлэх,		Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь хэрэгжүүлсэн.	90-ээс дээш хувь хэрэгжүүлнэ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар 2024 онд "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 364.5 сая төгрөгийг баталсан. Тус дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 9 төсөл, арга хэмжээг 303.0 сая төгрөгөөр хэрэгжүүлж, 8,200 гаруй иргэнд хүрч	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	<p>бүтээлч сэтгэлгээтэй, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлнэ. /Залуучуудын чуулга уулзалт, сургалт, өдөрлөг, арга хэмжээ гэх мэт/</p>					<p>ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь. Үүнд: Дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд “Гамшгийн үед ажиллах сайн дурын ажилтан бэлтгэх” төслийг хэрэгжүүлж, үер усны аюулын эрсдэл өндөр байгаа дүүргийн 4-10, 12, 13, 24 дүгээр хороо, туул голын дагуу амарч зугаалж байгаа иргэдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх мэдээлэл, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний зааварчилгаа өгөх, анхны тусламжийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үер усны аюулын үед ажиллах сайн дурын ажилтнуудыг бэлтгэн 2024 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс 9 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллуулж, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн. 2 дугаар зорилтын хүрээнд "Ээж бол ертөнц" төслөөр Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэйчүүд, одонтой ээжүүдэд хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг хороодоор дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуул, 25 хорооны 7500 эмэгтэйчүүдийг хамруулсан. 3 дугаар зорилтын хүрээнд "TedxKhanUul" төслийг хэрэгжүүлэн “TEDxKhanUul” олон улсын илтгэлийн арга хэмжээг Гэгээнтэн кино театрын 4 дүгээр танхимд 2024 оны 10 дугаар</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						сарын 06-ны өдөр зохион байгуулан 25 хорооны 100 залуусыг хамруулсан. 4 дүгээр зорилтын хүрээнд "Хан-Уул хөл бөмбөгийн клуб"-ын тамирчдад дэмжлэг үзүүлэх төслийг хэрэгжүүлэн Хан-Уул хөл бөмбөгийн клубын дугуйланд хичээллэж буй 8-12 хүртэлх насны 20 гаруй хүүхдийн хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлсэн. Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны залуучуудын аварга шалгаруулах сагсан бөмбөг, волейболын тэмцээнийг 2024 оны 4 дүгээр сарын 07-14-ний өдрүүдэд зохион байгуулж, тус хорооны нийт 225 залуусыг хамруулсан. "Хөгжөөн дэмжигчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх", "Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах таеквондогийн тэмцээнд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх", "Олон улсын сонсголын бэрхшээлтэй иргэдийн Ази Номхон далайн бүсийн нээлттэй тэмцээнд оролцох сагсан бөмбөгийн тамирчдад дэмжлэг үзүүлэх" төслүүдийг хэрэгжүүлэн нийт 6 тамирчинд замын зардлын дэмжлэг үзүүлсэн.	
Зорилт 24 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.5.8/							
32	Арга хэмжээ: 24.1 Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүний тэгш	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 аян, 7 сургалт	3 аян, 10-аас доошгүй сургалт	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар баталсан "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн 4 зорилт, 10 арга хэмжээний хүрээнд 3	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	эрх, боломж баталгааг хангаж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.					<p>төсөл, арга хэмжээг 60.0 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>1.Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хүрээнд иргэдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх хандлагыг төлөвшүүлж, сэтгэл зүйн эрүүл мэндэд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, сэтгэл зүйн хямралд өртөх эрсдэлийг бууруулах зорилгоор “Сэтгэл зүйн кабинет”-ийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс хамтран 2024 оны 02 дугаар сараас 08 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд байгуулсан. Төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл болон бусад төрлийн хүчирхийлэлд өртсөн 250 гаруй хүүхэд, эмэгтэйчүүдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн. Иргэд, олон нийтийн жендэрийн боловсрол, соёлыг дээшлүүлэх талаар нийгмийн бүх түвшинд жендэрийн хэвшмэл ойлголтыг багасгах, сөрөг хандлагыг бууруулах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан, 25 хороодын 1250 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>2.Зэвсэгт хүчний 120 дугаар цэргийн ангид “Жендэрийн мэдээлэл, сургалт”-ын танхим байгуулан 20,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 2024 оны 2 дугаар улиралд “Эмэгтэйчүүдийн оролцоо</p>	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						байгууллагын хөгжилд нөлөөлөх нь”, “Төрийн албанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо түүний эрх тэгш байдлыг хангах арга зам” зэрэг сэдвийн хүрээнд 6 цагийн сургалтыг ангийн нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан. 3.Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн “Камержуулалтын төсөл”-ийг хэрэгжүүлж, жөндөрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн. 4.Жөндөрийн тухай болон жөндөрийн хэвшмэл ойлголтыг халах, жөндөрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор "Харилцан хүндэтгэе", "Жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоног" 2 удаагийн аяныг зохион байгуулж, цахим орчинд болон танхимаар давхардсан тоогоор 250,00 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн. 5.Жөндөрийн Үндэсний хорооноос зохион байгуулсан "Жөндөрийн сургагч бэлтгэх" ахисан түвшний сургалтад Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагчийг хамруулсан.	
Зорилт 25 Асуудлыг шийдвэрлэх оновчтой хувилбарыг боловсруулж хэвшинэ.							
33	Арга хэмжээ: 25.1 Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар иргэн, хуулийн	-	Шүүхэд төлөөлсөн үйл ажиллагааны хувь	16 хэрэг маргаанд 100% оролцсон	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 100% төлөөлөн	Иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлтэй 18 хэрэгт итгэмжлэлийн үндсэн төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна. Үүнээс Захиргааны	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	этгээдээс гаргасан гомдол, маргаан, нэхэмжлэлтэй холбогдуулан итгэмжлэлийн үндсэн дээр хууль хяналтын байгууллагатай харилцана				оролцсон байна.	хэргийн шүүхэд 11 , Иргэний хэргийн шүүхэд 7 хэрэг байна. 2024 онд анхан шатны шүүхийн хуралдаанд 37, давж заалдах шатны шүүхийн 9 нийт 46 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцож: - Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 2, - Актын биелэлтийг түдгэлзүүлсэн 1 хэрэг маргаан байна. - Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн 4 хэрэг байна.	
Стратегийн 1 дүгээр зорилгын хүрээнд 25 зорилтын 33 арга хэмжээ 97.3 хувь хэрэгжсэн.							
Стратегийн зорилго 2. Хяналт-шинжилгээний үр дүнд тулгуурлан бодлого, шийдвэрийн төлөвлөлт, зохицуулалтыг хийж хэвшинэ.							
Зорилт 26 Бодлого, шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилтийн өөрчлөлтийг холбогдогч талуудад тасралтгүй мэдээлнэ. /СТ2.1/							
34	Арга хэмжээ: 26.1 Засгийн газрын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үр дүнг холбогдох байгууллагад тогтмол мэдээлнэ.	-	Холбогдох дээд шатны байгууллагад нэгтгэж, хүргүүлсэн тайлангийн тоо Хэрэгжилтийн хувь	5 тайлан 8 удаа тайлагнасан. Жилийн дундаж биелэлт 95%	5 тайлан 12-оос доошгүй удаа тайлагнаж, жилийн дундаж биелэлт 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 3 бүлэг, 9 зорилт, 11 арга хэмжээ эхний улиралд 47%, хагас жилийн байдлаар 66,25%, гуравдугаар улиралд 2 зорилго, 7 зорилт 8 арга хэмжээ 70%, хяналт шинжилгээ, үнэлгээний 5 шалгуур үзүүлэлт эхний улиралд 44%, хагас жилээр 55%, гуравдугаар улиралд 60%, 2020-2023 оны 4 жилийн хэрэгжилтийг дунджаар 98%, Таван жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 2 зорилт 4 арга хэмжээ хагас жилээр 50%, гуравдугаар улиралд 77,5%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 шалгуур үзүүлэлт 100%, 2021-2024	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 95%, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 1 зорилт, 2 арга хэмжээ эхний улиралд 50%, хагас жилээр 75%, гуравдугаар улиралд 85%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 шалгуур үзүүлэлт эхний хагас жилд 65%, эрчимжүүлэх шаардлагатай байсан бол гуравдугаар улиралд 85%, тодорхой үр дүнд хүрсэн бөгөөд сар бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнасан. Жилийн эцсийн тайлан нэгтгэгдэж байна.	
35	Арга хэмжээ: 26.2 Нийслэлийн Засаг даргын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үр дүнг холбогдох байгууллагад тогтмол мэдээлнэ.	-	Холбогдох дээд шатны байгууллагад нэгтгэж, хүргүүлсэн тайлангийн тоо Хэрэгжилтийн хувь	5 тайлан 4 удаа тайлагнасан. Жилийн дундаж биелэлт 92%	5 тайлан 4-өөс доошгүй удаа тайлагнаж, жилийн дундаж биелэлт 90%-аас доошгүй хувьтай хэрэгжилтийг хангуулна.	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 5 бүлэг, 9 зорилт 47 арга хэмжээ эхний улиралд 63%, хагас жилд 74%, гуравдугаар улиралд 84%, хяналт шинжилгээ, үнэлгээний 3 бүлгийн 35 шалгуур үзүүлэлт эхний улиралд 60%, хагас жилээр 34 шалгуур үзүүлэлт 64%, гуравдугаар улиралд 78%, Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээ эхний улиралд 47%, хагас жилээр 63%, гуравдугаар улиралд 73%, хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт эхний улиралд 47%, хагас жилээр 63%, гуравдугаар улиралд 73%, 2021-2025 оны 4 жилийн	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 90%, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 15 арга хэмжээ эхний хагас жилийн байдлаар 51%, гуравдугаар улиралд 77%, хяналт шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт эхний хагас жилээр 43%, гуравдугаар улиралд 67%, эрчимжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүр тайлагнасан. Жилийн эцсийн биелэлт нэгтгэгдэж байна.	
36	Арга хэмжээ: 26.3 Дүүргийн Засаг даргын бодлогын баримт бичгийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үр дүнг холбогдох байгууллагад тогтмол мэдээлнэ.		Хэрэгжилтийн хувь	2 тайлан 2 удаа тайлагнасан. Жилийн эцсийн биелэлт 90.4%	2 тайлан 2-оос доошгүй удаа тайлагнаж, жилийн дундаж биелэлт 90%-аас доошгүй хувьтай хэрэгжүүлнэ.	Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 114 зорилт, 151 арга хэмжээ эхний хагас жилд 57,8%, хяналт шинжилгээ, үнэлгээний 164 шалгуур үзүүлэлт 63%, эрчимжүүлэх шаардлагатай байсан бол гуравдугаар улиралд 151 арга хэмжээний биелэлт 73.5%, хяналт шинжилгээ, үнэлгээний 164 шалгуур үзүүлэлт 74%, тодорхой үр дүнд хүрсэн. Тайлангуудыг тухай бүр удирдлагад танилцуулж, үр дүнгүй болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг эрчимжүүлэх тухай хяналт шинжилгээ үнэлгээний ажлын 2024/02, 2024/03 дугаар зөвлөмжүүдийг холбогдох хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг тооцон	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						ажилласан. Жилийн эцсийн биелэлт нэгтгэгдэж байна. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021-2024 оны 4 жилийн биелэлт нэгтгэх ажлын хүрээнд урьдчилсан байдлаар 2021-2023 оны биелэлт нэгтгэгдсэн. Хяналт шинжилгээ, үнэлгээний 164 жилийн шалгуур үзүүлэлтийн 4 жилд хүрсэн түвшинг нэгтгэхэд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар дунджаар 90%, “Үр дүнтэй” байна.	
Зорилт 27 Бодлого, шийдвэр (боловсруулалт, төлөвлөлт, зохицуулалт, хэрэгжилт)-ийн хяналт-шинжилгээний үр дүнд илэрсэн алдаа, доголдлыг бүрэн залруулдаг болно. /СТ-2.4/							
37	Арга хэмжээ: 27.1 Дээд шатны байгууллагаас хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийг хангуулна.		Хяналт-шинжилгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2 удаа тайлагнасан. Зөвлөмжийн жилийн эцсийн биелэлт 93%	2-оос доошгүй удаа зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, жилийн дундаж биелэлт 90%-аас доошгүй хувьтай хэрэгжүүлнэ.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмж ирүүлээгүй.	-
38	Арга хэмжээ: 27.2 Дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлнэ.		Харьяа байгууллагад хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ болон зөвлөмжийн тоо	2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох байгууллагад 6 зөвлөмж хүргүүлсэн.	2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан байна.	Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2024/01 дугаар зөвлөмжийг 2024 оны 02 дугаар сарын 06-ны 03/214 тоот албан бичгээр 28 байгууллагад хүргүүлсэн. Хагас жилийн үйл ажиллагааны явцад хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайланг удирдлагад танилцуулж, 2024/02 дугаар зөвлөмжийг 2024 оны 08	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						дугаар сарын 202-ны 03/1661 тоот албан бичгээр дүүргийн Засаг даргын дэргэдэх 29 байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.	
81	Арга хэмжээ: 38.22 Төрийн архивд төлөвлөгөөт нөхөн бүрдүүлэлт хийгдэх байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Байгууллагын тоо	БНШАЗКомисс 6 удаа хуралдаж 30 байгуулла-гын данс бүртгэлийг зааврын дагуу үйлдүүлэн баяжилт хийгдсэн.	Төрийн архивт хөмрөг үүсгэгч 32 байгууллагын данс бүртгэлийг дүүргийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэн, батлагдсан данс бүртгэлийн дагуу төрийн архивт бүрдүүлэлт хийсэн байна.	Нөхөн баяжилтын төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу нөхөн баяжилт хийгдэх 32 байгууллагын данс бүртгэлийг архивын арга зүйн үүднээс хянан шалгаж Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2024 онд 5 удаагийн хурлаар хэлэлцэн баталж, 32 байгууллагын 2580 баримтыг дүүргийн архивт хүлээн авч ажилласан.	100%
82	Арга хэмжээ: 38.23 Байгууллагын архивд нөхөн баяжилт хийгдэх ажлыг зохион байгуулна.	-	Хүлээн авсан баримтын тоо	2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт 717 хадгаламжийн нэгжээр баяжилт хийгдсэн.	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2023 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт болон тусгай төрлийн баримтыг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу хүлээн авна.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадад 2023 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтаар байгууллагын архивт нөхөн баяжилт хийх хуваарийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан, хуваарийн дагуу хэлтэс, албадаас баримтыг архивт хүлээн авч баяжилт хийгдэж байна. -Байнга хадгалах 204 хадгаламжийн нэгж -70 жил хадгалах 6 хадгаламжийн нэгж -Түр хадгалах 540 хадгаламжийн нэгж -Байгууллага дээр байнга хадгалах 14 хадгаламжийн нэгж, нийт 764 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч, төрөлжүүлэн цэгцэлж, дугаарлалт хийн бүртгэл үүсгэсэн.	100%
83	Арга хэмжээ: 38.24	-	Байгууллагын тоо	Хөмрөг үүсгэгч 94 байгууллагын	Хөмрөг үүсгэгч 104 байгууллагын	Хөмрөг үүсгэгч 105 байгууллагын 2023 онд үүссэн захирамжлалын	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	Хөмрөг үүсгэгч байгууллагын захирамжлалын баримтын цахим нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг төлөвлөж, удирдан зохион байгуулна.			2022 оны захирамжлалын баримтын цахим бүрдүүлэлтэд батлан шалгалт хийж, хяналт тавьсан.	2023 оны захирамжлалын баримтын цахим бүрдүүлэлтэд батлан шалгалт хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.	баримтыг төрийн архивын нэгдсэн системд 204 хадгаламжийн нэгжийн 12806 баримтын 19936 хуудсыг цахимжуулсаныг батлан шалгаж ажилласан.	
84	Арга хэмжээ: 38.25 Цаасан суурьт захирамжлалын баримтыг цахим хэлбэрт хувиргах ажлыг зохион байгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	Захирамжлалы н 1022 баримтаар 100 хувь цахим бүрдүүлэлт хийгдсэн.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын захирамжлалын баримтын цахим бүрдүүлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, батлан шалгалтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэнэ.	Засаг даргын Тамгын газрын 2023 онд үүссэн <ul style="list-style-type: none"> ➢ Засаг даргын “А” захирамж 771 баримт бүхий 1962 хуудастай 9 боть ➢ Засаг даргын “Б” захирамж 97 баримт бүхий 112 хуудастай 1 боть ➢ Засаг дарын Тамгын газрын даргын “А” тушаал 115 баримт бүхий 256 хуудастай 2 боть Засаг дарын Тамгын газрын даргын “Б” тушаал 295 баримт бүхий 388 хуудастай 2 боть нийт 1278 захирамжлалын баримтыг сканердаж www.Arch.ulaanbaatar.mn системд шивж баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн, нийт 14 хадгаламжийн нэгжийн 1278 баримтын, 2718 хуудас бүхий баримтад нягтлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
85	Арга хэмжээ: 38.26 Төрийн албан албан хаагчдын хэрэгцээнд	541.0	Худалдан авах ажиллагааны явц, хувь	-	100	Төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх компьютер тоног төхөөрөмжөөр хангах ажлын	100%

Д/ д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /15, 16 хороо, ЦГ, ЗЦХ, УБХ, ХГБЗХХ/					<p>хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 6 төсөл, арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн тамгын газар, Татварын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Замын цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэхээр төлөвлөсөн. Төсөл, арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> •“Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Сүүхүнгий ХХК шалгарч 24 тоног төхөөрөмж, 42 тавилга нийлүүлсэн. •“Төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд компьютер, тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Саммит компьютер технологи ХХК шалгарч гэрээ байгуулсан. 35 ширхэг суурин компьютер нийлүүлэгдсэн. •“Хан-Уул дүүргийн цагдаагийн газар, Замын цагдаагийн хэлтсийн албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Сүүхүнгий ХХК шалгарч 95 ширхэг компьютер тоног төхөөрөмж нийлүүлсэн. • “Төрийн байгууллагын албан хэрэгцээнд тавилга тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээний Багц-1-ын гүйцэтгэгчээр Голденхоул ХХК шалгарч, Замын 	

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						цагдаагийн газарт 22 ширхэг компьютер тоног төхөөрөмж, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 17 ширхэг компьютер тоног төхөөрөмж, 114 дүгээр сургуульд 23 ширхэг хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмж нийлүүлсэн. • “Хан-Уул дүүргийн цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж, зөөврийн харуулын байр худалдан авах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Сүүхүнгий ХХК шалгарч Хан-Уул дүүргийн цагдаагийн газарт 163 ширхэг компьютер тоног төхөөрөмж, 17 ширхэг тавилга, 1 зөөврийн хяналтын цэгийн байр нийлүүлэгдсэн. • “Онцгой байдлын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээний хүрээнд Хан-Уул гал унраах аврах 14, 30, 63 дугаар ангиудал 3 ширхэг аврах баг цэнэглэдэг компрессор нийлүүлэгдсэн.	
86	Арга хэмжээ: 38.27 Төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин худалдан авах /ЦГ, ХГБЗХХ/	140.0	Худалдан авсан авто машин, тоо	-	2	Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, ойроос хүргэх зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17-р хорооны Кинг товер хотхонд 250 м.кв байр худалдан авч өрхийн эмнэлгийн үйл ажиллагааг явуулж байна.	100%
87	Арга хэмжээ: 38.28 Хорооны байр худалдан авах засварлах ажлыг хэрэгжүүлж, иргэд үйлчилгээ авах	1,050.0	Худалдан авсан хорооны байр, тоо	4 /2021-2023 он/	1	Дүүргийн төсвийн 100 сая төгрөгийн хөрөнгөөр 9 дүгээр хорооны байрны дотор засал, фасад засварын ажлыг хэрэгжүүлж дууссан.	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	тохиромжтой орчныг бүрдүүлнэ.	100.0	Засварласан хорооны байр, тоо	-	1	Дүүргийн төсвийн 100 сая төгрөгийн хөрөнгөөр 9 дүгээр хорооны байрны дотор засал, фасад засварын ажлыг хэрэгжүүлж дууссан.	
		250.0	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу зам хийгдсэн хороо, тоо	-	8	Дүүргийн төсвийн 250 сая төгрөгийн хөрөнгөөр 4, 5, 6, 8, 13, 14, 20, 22, 23 дугаар хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор байрны гадна довжоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу замын ажлыг хэрэгжүүлж дууссан.	
88	Арга хэмжээ: 38.29 Төрийн байгууллагуудын барилгын засвар хийх, инженер хангамжийн шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлнэ /ГУА-14, СО, Яармаг ОНӨААТҮГ/	628.0	Засварласан барилга байгууламж, тоо	-	2	Дүүргийн төсвийн 288 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжиж буй Гал унтраах, аврах 14 дүгээр ангийн барилгын их засварын ажил (20 дугаар хороо)-ын гүйцэтгэгчээр “Баян Өндөр булаг” ХХК шалгарч, тус барилгын дотор засал болон метал фасад засварын ажлыг гүйцэтгэж албан хаагчдын тав тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.	100%
89	Арга хэмжээ: 38.30 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг хүсэлтийг судалж, холбогдох шатны байгууллагуудад санал хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн санал, тоо	137 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг судалж, холбогдох байгууллагад санал хүргүүлсэн.	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд санал авахаар ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг бүрэн судалж, шийдвэрлэнэ.	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэхээр Засаг даргын санал авах хүсэлт ирүүлсэн 200 иргэн, аж ахуй нэгжийн төсөл арга хэмжээний материалыг судалж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь хяналт тавин шаардлага хангасан 157 иргэн, аж ахуй нэгж байгууллагын төсөлд холбогдох саналыг БОУАӨЯ, НБОГ-т албан бичгээр санал хүргүүлсэн.	100%
90	Арга хэмжээ: 38.31 Сууц өмчлөгчдийн холбоог бүртгэх, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж, түвшин тогтоох, үзлэг шалгалтыг зохион байгуулна.	-	Шинээр бүртгэсэн, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт ордуулсан сууц	26 сууц өмчлөгчдийн холбоог шинээр бүртгэж, 124 гэрчилгээнд	Шинээр бүртгүүлэх, сунгалт, нэмэлт өөрчлөлт ирүүлсэн хүсэлтийг	Шинээр байгуулагдсан 41 сууц өмчлөгчдийн холбоог бүртгэж, 124 гэрчилгээнд сунгалт, нэмэлт өөрчлөлт оруулсан. Дүүргийн хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 356 сууц өмчлөгчдийн	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БҮЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
			өмчлөгчдийн холбоо, тоо	сунгалт, нэмэлт өөрчлөлт оруулсан.	бүрэн судалж, шийдвэрлэнэ.	холбооны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.	
		-	Түвшин тогтоох, үзлэг шалгалтад хамруулсан сууц өмчлөгчдийн холбоо, тоо	253 сууц өмчлөгчдийн холбоодыг түвшин тогтоох үзлэг шалгалтад хамруулсан.	200-аас доошгүй сууц өмчлөгчдийн түвшин тогтоох үзлэг шалгалтад хамруулна.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас сууц өмчлөгчдийн холбоодын түвшин тогтоох үзлэг шалгалтын чиглэл ирүүлээгүй. Хэрэгжилт тооцох боломжгүй.	
91	Арга хэмжээ: 38.32 Эзэнгүй нохой, муурын тоог бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	194.4 (ДТХО)	Бууруулах тоо толгой	8100 толгойгоор бууруулсан.	5000-аас багагүй толгойгоор бууруулсан.	Дүүргийн Засаг даргын 2024 оны А/03, А/153, А/296, А/622, А/705 дугаар захирамжийн дагуу устгалын мэргэжлийн байгууллага “Өлтэ” ХХК- тай гэрээ байгуулан дүүргийн хэмжээнд эзэнгүй нохой, муурны устгалыг тогтмол хуваарын дагуу зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн дуудлагын дагуу 25 хорооны хэмжээнд нийт 4998 эзэнгүй нохой, муурыг устгуулж, хяналт тавьж ажилласан.	100%
92	Арга хэмжээ: 38.33 Нийтийн бие засах газрын үйлчилгээ, арчлалт, хамгаалалтыг сайжруулж, засварлаж, тохижуулна.	330.0 (ДТХО)	Шинээр байгуулсан, засварлаж, тохижуулсан нийтийн бие засах газрын тоо	-	2 (Шинээр 1, засварлаж тохижуулах 1)	Хот нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжсэнтэй холбогдуулан 1 дүгээр хороонд байрлах 2, 22 дугаар хороо Дугуй цагааны тохижилттой талбайд байрлах 1 буюу нийт 3 нийтийн бие засах газрын арчлалт, хамгаалалтыг “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-т хариуцуулан хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/512 дугаар захирамжийн дагуу 22 дугаар хорооны Дугуй цагааны тохижилттой талбайн арчлалт,	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БҮЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						хамгаалалтыг “Хан-Уул Агро” ОНӨААТҮГ-т хариуцуулан өгсөн. Дүүргийн төсвийн 250.0 сая төгрөгөөр 9 дүгээр хороонд нийтийн бие засах газар байгуулах ажлын гадна талбайн тохижилтын ажил нь бүрэн хэрэгжсэн, барилга угсралтын ажил 2025 онд хэрэгжинэ.	
93	Арга хэмжээ: 38.34 Усны тоо бүртгэлийг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	Дүүргийн хэмжээнд усны тоо бүртгэлийн судалгааг Нийслэлийн Байгаль орчны газар, Туул голын сав газрын захиргаанаас авч нэгтгэн дүүргийн нийт уст цэгийн тооллогын судалгааг байгаль орчны мэдээллийн санд оруулсан. 2024 оны байдлаар дүүргийн хэмжээнд нийт 2249 уст цэг, 24 булаг, 4 рашаан, 12 гол горхи, 4 нуур, 3 хөв цөөрөм тоологдсон байна.	100%
94	Арга хэмжээ: 38.35 Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.		Хамрагдсан албан хаагчдын хувь	100	100	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны А/97, А/98, А/102 дугаар тушаалаар Тамгын газар болон хороодын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан. Үүнд: -Дүүргийн Нэгдсэн эмнэлэгт 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 114 хэсгийн ахлагчийг, -Интермед эмнэлэгт 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд Засаг даргын Тамгын газрын 75 албан хаагчийг, - Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотын эмнэлэгт 2024 оны 10 дугаар сарын 18-21-ний өдрүүдийн	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						хооронд Засаг даргын Тамгын газрын 13 албан хаагчийг, - Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хороодын Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтнууд нийт 85 албан хаагчийг үзлэг, оношилгоо болон өдрийн эмчилгээнд тус тус хамруулж нийт 291 албан хаагчид хамрагдсан. Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдвал зохих 164 албан хаагчид бүрэн хамрагдаж, нэмэлтээр 114 хэсгийн ахлагчдыг хамруулсан.	
95	Арга хэмжээ: 38.36 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу Цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах	8,0 сая	Цэргийн бүртгэлийн хамралтын хувь	95 хувьтай хэрэгжсэн.	Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу Цэргийн бүртгэлийн үйл ажиллагаа зохион байгуулагдана.	Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны “Цэргийн бүртгэл явуулах тухай” А/331 дүгээр журмыг удирдлага болгон дүүргийн Засаг даргын 2023 оны А/687 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 19-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг цахим болон цаасан суурьтай зохион байгуулахад 93,9 хувь хамрагдсан.	94%
96	Арга хэмжээ: 38.37 Батлан хамгаалахын сайдын, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг хэрэгжүүлэх	-	Гэрээний зүйл, заалт	94 хувьтай хэрэгжсэн.	Цэргийн штабын бэлэн байдал хангагдана.	Монгол Улсын Засгийн газрын Батлан Хамгаалах зарим чиг үүргийг Нийслэлд төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээнд 5 бүлэг 37 нэр төрлийн ажил, үйлчилгээ тусгагдсанаас гэрээний хэрэгжилт 99.8 хувьтай байна.	100%
97	Арга хэмжээ: 38.38 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай	70,0 сая	Цэрэг татлагын арга хэмжээг зохион	100 хувьтай хэрэгжсэн.	Зэвсэгт хүчин, Хилийн болон Дотоодын	Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу нэг, хоёрдугаар зэлжийн цэрэг татлагыг Нийслэлийн Засаг даргын	64%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БҮЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	хуулийн дагуу 2024 оны ээлжит цэрэг халалт, татлагын үйл ажиллагааг зохион байгуулах		байгуулсан эсэх, тоон даалгаврыг биелүүлсэн эсэх.		цэргийн нөхөн хангах тоон даалгавар биелэгдэнэ.	2024 оны А/399, А/1116, А/1227 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/181, А/611, А/652 дугаар захирамжийн дагуу Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн байрыг түшиглэн 05, 10 дугаар саруудад зохион байгуулж Зэвсэгт хүчний Жанжин штаб, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас өгсөн тоон даалгаврыг 64 хувь биелүүлсэн.	
98	Арга хэмжээ: 38.39 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2024 оны “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах	4,6 сая	“Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулсан эсэх, хамрагдсан оюутны тоо	“Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад 110 оюутан хамрагдсан.	Их, дээд сургуулийн оюутан болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн хугацаат цэргийн алба хаах боломж олгогдоно.	Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2024 оны А/126 дугаар захирамжийн дагуу “Оюутан-Цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл үндэсний портал сайт E-Mongolia бүртгэлийг хүлээн авсан. 2024 онд дүүргийн хэмжээнд 5 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан, суралцагчид бүртгэлд хамрагдсан. Бүртгэлд хамрагдсан оюутан, суралцагчдаас 108 иргэнийг эрүүл мэндийн үзлэг болон бие бялдрын шалгалтад оруулсан. Эрүүл мэндийн үзлэг, бие бялдрын шалгалтад тэнцсэн 74 оюутныг Үндэсний Батлан Хамгаалахын их сургуулийн Сургалтын албанд хүлээлгэн өгсөн.	100%
Стратегийн 6 дугаар зорилгын хүрээнд 3 зорилтын 41 арга хэмжээ 98.5 хувь хэрэгжсэн.							

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
<i>Стратегийн төлөвлөгөөний зорилго 7. "Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ".</i>							
Зорилт 39 Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор "Чанарын удирдлагын тогтолцоо"-г нэвтрүүлэх ажил зохион байгуулж, хороодын үйл ажиллагааны чадавхыг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Хорооны хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 3.1.2/							
99	Арга хэмжээ: 39.1 Хороодын хөгжил дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	Дэд хөтөлбөр 80%-тай хэрэгжсэн.	Дэд хөтөлбөрийг 90%-аас дээш хэрэгжүүлнэ.	Дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэх 5 зорилт, 14 арга хэмжээ бүхий төлөвлөгөө 93 хувьтай хэрэгжсэн. Төлөвлөгөөний хүрээнд тэргэнцэртэй иргэнд зориулсан налуу шатыг 9 хорооны байранд хийж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, харилцааны ур чадварыг сайжруулах чиглэлээр 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 171 албан хаагчийг хамруулж, албан хаагчдын 25 ширхэг компьютер, 3 принтерыг шинэчилж, 3 хорооны нэг цэгийн үйлчилгээнд дэлгэц олгон үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлсэн.	100%
100	Арга хэмжээ: 39.2 "Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлнэ.	-	Стандарт нэвтрүүлсэн хорооны тоо	3 хороонд ISO 9001:2015 стандарт нэвтрүүлсэн.	1-ээс доошгүй хороонд стандартыг нэвтрүүлсэн байна.	Чанарын удирдлагын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх хүрээнд зөвлөн туслах байгууллага, үнийн судалгаа хийж, "Сэцэн" чанарын менежментийн төвтэй хамтран дүүргийн 19 дүгээр хороонд сүүлийн хагас жилд чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн боловч төсөв хүрэлцэхгүй болсон тул 2025 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан.	10%
Зорилт 40 Засаг захиргааны анхан шатны нэгж хорооноос иргэдэд хүргэж буй үйлчилгээний төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлж, зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. /ДЗДҮАХ 3.2.2/							

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
101	Арга хэмжээ: 40.1 Хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ	-	Нэмэгдүүлсэн "Хурдан цэг"-ийн тоо	Төрийн үйлчилгээний 2 "Хурдан цэг" үйлчилгээ үзүүлсэн.	Төрийн үйлчилгээний "Хурдан цэг"-ийг 1-ээр нэмж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор "Хурдан" цэгийн үйлчилгээг 25 хороонд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах тоног төхөөрөмж, хаягжилтад зориулан дүүргийн төсвийн хөрөнгөөс 12,740,000 төгрөгийг зарцуулсан. "Хурдан" цэгийн үйлчилгээний нээлтийг 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр хийж, иргэд хорооноос нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт, иргэний үнэмлэхийн лавлагаа, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа, авто тээврийн хэрэгслийн торгуулийн мэдээлэл, жолоочийн лавлагаа зэрэг төрийн 43 байгууллагын 478 нэр төрлийн үйлчилгээг авах боломжтой болсон. Хан-Уул дүүргийн 25 хорооны албан хаагчид 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 1276 иргэнд "Хурдан" цэгийн үйлчилгээг үзүүлсэн.	100%
102	Арга хэмжээ: 40.2 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	3.0	Үзлэгт хамрагдсан хүн амын хувь	56 хувь	70 хувь	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх арга хэмжээг Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулж, эрүүл мэндийн даатгал бүрэн төлсөн амьжиргааны түвшин доогуур иргэдийн судалгааг гаргуулан эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд 120 иргэнийг, 25 хороодын хэсгийн ахлагчаас эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдаагүй судалгааг гаргаж 24	48%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						хэсгийн ахлагчийг тус тус эрт илрүүлэг үзлэг, оншилгоонд нийт 244 иргэнийг хамруулсан. Дүүргийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сараас 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүртэлх эрт илрүүлгийн хамрагдалтын хувь 48%-тай байна. Үүнээс: 0-5 нас 59.3%, 6-17 нас 67%, 18-30 нас 25,8%, 31-45 нас 31,2%, 46-60 нас 48,9%, 61-ээс дээш 59,4%-тай хамрагдсан. Дүүргийн хүн амын тоо 258,187 болж нэмэгдсэнтэй холбоотой эрт илрүүлгийн хувь 48% болж өөрчлөгдсөн.	
Зорилт 41 Дүүргийн “Иргэдийн спортын их наадам”-ыг жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /ДЗДҮАХ 2.1.1/							
103	Арга хэмжээ: 41.1 Дүүргийн төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулна.	30.0	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Дүүргийн Иргэдийн спортын XII их наадмыг 2024 оны 05 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд 3 үе шаттайгаар явган аялал, орс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр байгуулж 24 хорооны нийт 6558 иргэнийг хамруулсан. Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын спорт явган аялалын шигшээ тэмцээн 2024 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Налайх дүүргийн Тайж хайрханы бэлд, орс таталтын шигшээ тэмцээн 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны зааланд, сагсан бөмбөг, волейбол, дартс, ширээний шагайн наадгай, софт волейбол, хийн	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						дасгал, аеробикийн шигшээ тэмцээнүүд 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд Буянт-Ухаа спорт ордонд зохион байгуулагдаж, Хан-Уул дүүргийн 10 хорооны 15 багийн 180 тамирчин оролцож багийн нэгдсэн дүнгээр Тэргүүн байр эзэлсэн.	
Зорилт 42 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.2.2/							
104	Арга хэмжээ: 42.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн "Уулзалт өдөрлөг", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдөр"-ийг угтсан олон талт арга хэмжээ зохион байгуулна.		Хамрагдсан иргэдийн тоо, хэрэгжүүлсэн арга хэмжээ	2 арга хэмжээнд 550 иргэнийг хамруулсан.	3-аас доошгүй арга хэмжээнд 600 иргэн хамруулна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, эрх зүйн мэдлэг олгох, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Сонсголгүй иргэдийн 3х3 сагсан бөмбөгийн холбоо"-той хамтран 2024 оны 01 дүгээр сард зохион байгуулсан 5 дахь удаагийн нөхөрсөг тэмцээнд 80 иргэн, 2024 оны 4 дүгээр сард Монголын Бочигийн холбооноос зохион байгуулсан "Хамтдаа суралцъя, Хамтдаа тоглоё, Хамтдаа хөгжье" уриатай бочигийн тэмцээнд 18 сурагчийг тус тус оролцуулсан. Авлигатай тэмцэх газартай хамтран авлигыг үл тэвчих, нийгэмд учруулах хор аюулыг ойлгуулах сургалтыг 2024 оны 9 дүгээр сард зохион байгуулж 105 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй 12 өрхөд дүүргийн Засаг даргын захирамжаар 5 ханатай гэр болон Олон улсын сонсголын бэрхшээлтэй иргэдийн сагсан бөмбөгийн Ази Номхон далайн бүсийн нээлттэй тэмцээнд оролцох дүүргийн	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>3 тамирчинд 3.8 сая төгрөгийн дэмжлэг олгосон.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах олон улсын өдрийг угтан 3 арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>Дэлхийн хараагүйчүүдийн эрхийн өдрийг тохиолдуулан 2024 оны 10 дугаар сард харааны бэрхшээлтэй 180 иргэнд хүнсний дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Дүүргийн Пара болон Тусгай бочигийн нээлттэй тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулж, 50 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулсан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн “Асуудал-Шийдэл” өдөрлөгийг 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулж, 125 эцэг эхийг хамруулсан.</p>	
Зорилт 43 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.3.3/							
105	Арга хэмжээ: 43.1 Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах, ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж ажиллана.		Өргөтгөсөн худалдаа зохион байгуулсан байршлын тоо, борлуулалт	9 байршилд 459.1 тн мах, 920 тн хүнсний ногоо худалдан борлуулсан.	Маж, төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулагдсан байна.	Иргэдийн хүнсний хангамжийн нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах ажлын чиглэлээр: - Нөөцийн махны худалдааг хүнсний болон сүлжээ 41 дэлгүүр, өргөтгөсөн худалдаагаар нийт 209,3 тонн махыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, махны чанар, хадгалалт, борлуулалтад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж, иргэдээс ирсэн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан. - Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон жижиглэн худалдааг 5 байршилд зохион байгуулж, нийт 30	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						газар тариалан эрхлэгчийн 97.2тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулж, 143.3сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажилласан.	
Зорилт 44 Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулж, хүн амын хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаална. /НЗДҮАХ 3.3.2/							
106	Арга хэмжээ: 44.1 Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.		Хамрагдсан малын тоо, хэрэгжилтийн хувь	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 9 удаагийн дархлаажуулалтад 340708 мал, амьтан хамрагдаж, 97.2 хувь, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 удаагийн дархлаажуулалтад 105425 бог мал, гүйцэтгэл 98.9 хувь	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар,	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Мал эмнэлгийн үйлчилгээ, хяналтын чадавхыг сайжруулах мал эмнэлгийн нэгжтэй мал эмнэлгийн нэгжүүдтэй ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх гурвалсан гэрээг шинэчлэн байгуулж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны байдлаар Мал эмнэлгийн ажил үйлчилгээнд 6 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, Засаг даргын нөөцөөс 29.2 сая төгрөгийг үйл ажиллагааны зардлыг олгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан буюу https://livestock.mofa.gov.mn/ цахим системд 2023 оны мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 781 өрхийн 46919 мал болон хорогдсон 2050 малыг тус тус бүртгэн мэдээллийн санд оруулсан. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 4 удаагийн дархлаажуулалтад 136070 мал,	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						<p>амьтан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 7 удаагийн дархлаажуулалтад 227951 мал, амьтныг тус тус хамруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2024 оны 2 удаагийн захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулж, 3389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 12000м2 талбай, 11000м2 талбай бүхий хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг дүүргийн мал эмнэлгийн тасаг, Тохижилт үйлчилгээний төвтэй хамтран зохион байгуулж ажилласан.</p>	
<p>Зорилт 45 Хүнсний зохистой хэрэглээ, аюулгүй, баталгаат хүнс сонгох талаар хэрэглэгчийн боловсролыг сайжруулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна./ НЗДҮАХ-3.3.3/</p>							
107	<p>Арга хэмжээ: 45.1 Хүнсний аюулгүй байдал, зөв зохистой хэрэглээ, эрүүл баталгаат хүнс сонгох талаар иргэд, олон нийтэд сурталчлах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж ажиллана.</p>	5.0	<p>Зохион байгуулсан сургалт сурталчилгааны тоо</p>	2	<p>4-өөс доошгүй удаагийн сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, зохистой хэрэглээний талаар хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор 4 удаагийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж 426 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Үүнд.</p> <ol style="list-style-type: none"> "Хүнс эрүүл бол хүн эрүүл" сургалт; Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдааны техникийн зохицуулалтыг хангуулах нь сургалт; Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанар аюулгүй 	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						байдал, хадгалалт хамгаалалтад хяналт тавих нь сургалт; “Өсвөр үеийн эрүүл мэндийг хамгаалах, электрон тамхины хэрэглээг бууруулах” сэдэвт өдөрлөг, арга хэмжээ, сургалт;	
Зорилт 46 Дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих “Эко хүлэмж” арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 1.3.1/							
108	Арга хэмжээ: 46.1 Хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин, жимс, жимсгэний суулгац, үржүүлгийн талаар сургалт зохион байгуулж, хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.		Зохион байгуулсан арга хэмжээний тоо, дэмжин ажилласан газар тариалан эрхлэгчдийн тоо	5 арга хэмжээ зохион байгуулж, 173 өрхийн тариалалтыг дэмжсэн.	5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 180 иргэнийг дэмжин ажилласан байна.	Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран “Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах технологи”, “Хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам сурталчлах 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 102 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Мөн төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 6.3 сая төгрөгийн үнэ бүхий 10 нэр төрлийн 825.5 кг хүнсний ногооны үрийг 13, 14 дүгээр хорооны 366 өрхөд үнэ төлбөргүй олгож, өрхийн тариалалтыг дэмжиж ажилласан.	100%
109	Арга хэмжээ: 46.2 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, иргэн аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчлах, дэмжих, урамшуулах ажлыг зохион байгуулна.	10.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	3 арга хэмжээнд 300 гаруй аж ахуйн нэгж хамрагдсан.	4 арга хэмжээ зохион байгуулж, 300-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулна.	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл, үл хөдлөх жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хууль тогтоомжийг сурталчлах, дүүрэгт хийгдэж буй	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг танилцуулах, салбарт тулгамдаж асуудлыг хэлэлцэх зөвлөлдөх уулзалтыг 12 удаа зохион байгуулж, 912 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.	
Стратегийн 7 дугаар зорилгын хүрээнд 8 зорилтын 11 арга хэмжээ 87.1 хувь хэрэгжсэн.							
Стратегийн 7 зорилгын хүрээнд 46 зорилт 109 арга хэмжээний хэрэгжилт 96.8 хувь хэрэгжсэн							
НЭМЭЛТ АЖИЛ							
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 47. Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд							
110	Арга хэмжээ: 47.1 “Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүсийг тогтоож, дагаж мөрдөх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Журмын хэрэгжилт, хувь	-	-	“Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүсийг тогтоож, дагаж мөрдөх журам”-н төслийг боловсруулах ажлын хэсгээс журмын төслийг нийтэд дагаж мөрдөх журмаар бүртгүүлэхээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн байна. Хэрэгжилт тооцох боломжгүй.	-
Зорилт 48. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд							
111	Арга хэмжээ: 48.1 Орон нутгийн суурь зардалд туссан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусдаа хавсралтаар ИТХ-аар батлуулна. (хөрс, ой, амьтан, ургамал, ус рашаан,)	-	Батлагдсан шийдвэр, тоо (СЯ-ны баталсан дүнг үндэслэх)	-	-	Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 26 дугаар тогтоолоор баталсан дүүргийн 2024 оны төсөвт Байгаль хамгаалах, ойжуулах, цэцэрлэгжүүлэх зардалд 2,302,400,000 төгрөгийг баталсан. Тус зардлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны задаргааг хуульд нийцүүлэн дүүргийн ИТХ-аар хэлэлцүүлэн төсвийн тодотголоор батлуулахаар судалж байна.	-

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
Зорилт 49. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, бохирдол багатай ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд							
112	Арга хэмжээ: 49.1 Өрхийн хэрэгцээнд сэргээгдэх эрчим хүч ашиглаж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нүүрстөрөгчийн кредитийг тооцоолох, баталгаажуулах туршилтын төслийг эхлүүлж, цаашид төсөлд хамрагдах айл өрхийн тоог нэмэгдүүлэх боломжийг судлан шийдвэрлэнэ.	1,841.7	Сэргээгдэх эрчим хүч ашигласан айл өрх, тоо	-	-	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2024-2025 оны өвөл 35 айлд сэргээгдэх эрчим хүч ашиглаж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нүүрстөрөгчийн кредитийг тооцоолох, баталгаажуулах туршилтын төслийг эхлүүлж, цаашид төсөлд хамрагдах айл өрхийн тоог нэмэгдүүлэх боломжийн судалгаа хийгдэж байна. Тус судалгааны үр дүнд үндэслэн дараагийн шатны арга хэмжээг нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлнэ.	-
113	Арга хэмжээ: 49.2 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон халаалтын зуухнаас ялгарах үнс, тоосонцрын хэмжээнд магадлал итгэмжлэл хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж, бууруулна.	50,0	Хамруулах байгууллагын тоо	26	15	100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон халаалтын зуухнаас ялгарах үнс, тоосонцрын хэмжээнд магадлал итгэмжлэл 41 зууханд хийснээс “Түмэн шувуут” ХХК-4, “Вагро”ХХК-2, “Живэртийн оргил”-2, Био комбинат ТӨҮГ-н 4 зуух нийт 11 зууханд “Магадлан итгэмлэх гэрчилгээ” олгохоор шийдвэрлэсэн. Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар дүгнэлтийн дүн ирээгүй байна. Тус дүн ирсэнээр дүүргийн Засаг даргын захирамжийг гаргаж, батламж олгоно.	100%
Зорилт 50. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах хүрээнд							
114	Арга хэмжээ: 50.1 Засгийн газрын 2018 оны “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” 189		Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	-	Засгийн газрын 2018 оны “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” 189 дүгээр тогтоолыг дүүргийн нутаг дэвсгэрт хоол	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.					үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 276 иргэн, аж ахуйн нэгжид танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах талаар зөвлөмж, мэдээлэл хүргүүлж ажилласан. Мөн иргэд олон нийтэд мэдээллэх, таниулах зорилгоор зурагт хуудас, постер бэлтгэн цахим мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан.	
115	Арга хэмжээ: 50.2 “Дэлхийн хөрсний өдөр”, “Нийслэлийн хөрс хамгаалах өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулахад хамтарч ажиллана.	5.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	2	Жил бүрийн 12 дугаар сарын 05-ны өдөр “Дэлхийн хөрсний өдөр”, 04 дүгээр сарын 27-ны өдөр “Нийслэлийн хөрсний өдөр” тохиодог. Нийслэлийн байгаль орчны газраас “Нийслэлийн хөрсний өдөр”-ийг тохиолдуулан 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан өдөрлөг арга хэмжээнд чиг үүргийн 2 албан хаагч оролцсон. Нийслэлийн байгаль орчны газраас “Дэлхийн хөрсний өдөр”-ийг тохиолдуулан 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Монгол орны хөрс судлал 2024” эрдэм шинжилгээний бага хуралд 2 албан хаагч оролцуулсан.	100%
Зорилт 51.Усны нөөцийн ашиглалт, хамгаалах хүрээнд							
116	Арга хэмжээ: 51.1 Рашаан, булгийн эхийг тохижуулж, хамгаална.	15.0	Тохижуулсан эх, тоо	21	22	Дүүргийн Засаг даргын 2024 оны А/636 дугаар захирамжийн дагуу 14 дүгээр хорооны 5 дугаар хэсэгт байрлах “Ар булгийн эх”-ийн хог хаягдлыг цэвэрлэж, байгалийн аргаар урсацыг нэмэгдүүлэн орчныг хашиж хамгаалсан. Төсөв: 19,000,000 төгрөг	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
Зорилт 52. Аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд							
117	Арга хэмжээ: 52.1 Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээг хамтран зохион байгуулна.	400.0	Оролцох арга хэмжээ, тоо	6 арга хэмжээнд оролцсон	7	Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад, дотоодын жуулчдад таниулах зорилгоор Нийслэлийн аялал жуулчлалын газар, төрийн бус байгууллага, холбоодтой хамтран 7 удаагийн олон нийтийн арга хэмжээнд дүүргийн нутаг дэвсгэрт зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор 96 аж ахуйн нэгжийг хамруулж бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан, хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Үүнд: - “Бүргэдийн баяр” арга хэмжээ - “Тэнгэр” олон улсын бөө мөргөлийн фестиваль - “Улаанбаатар марофон” арга хэмжээ - “Улаанбаатар Травэл Экспо- 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн - “Нүүдэлчин монгол” фестиваль - “ITM- Монголиа-2024” үзэсгэлэн арга хэмжээ - “Зочлох үйлчилгээний салбарын ханган нийлүүлэлтийн үзэсгэлэн” арга хэмжээ	100%
118	Арга хэмжээ: 52.2 Аялал жуулчлал, үйлчилгээний байгууллагын нэгдсэн бүртгэлийг хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Дотоод, гадаадын жуулчдад салбарын мэдээллийг онлайнгаар хүргэх зорилгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
						ажиллагаа эрхэлж байгаа зочид буудал, дэн буудлын цахим мэдээллийн санг үүсгэж зорилгоор судалгаа мэдээллийг шинэчилсэн боловсруулсан. Мөн худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд 2024 онд зочлох үйлчилгээний салбарын 22 хүсэлт бүртгэгдсэн.	
119	Арга хэмжээ: 52.3 Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хамтран ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин ажилласан. Үүнд: - Гэр бүл, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор 2 байршилд гэрлэн чимэглэл бүхий талбай тохижуулж, Богдхааны ордон музейн цэцэрлэгт хүрээлэнд “Christmas market” худалдаа үйлчилгээг зохион байгуулж худалдаа, хоол үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 20 иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүн, үндэсний хоолыг сурталчлан, борлуулалтыг дэмжин ажилласан. - Өвлийн улирлын экстрем спорт, аяллын төрлүүдийг иргэд, олон нийтэд сурталчлах, ёс заншил, өв улалмжлалыг залуу үедээ өвлүүлэх зорилгоор “Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээнд зочлох үйлчилгээний салбарын 5 аж ахуйн нэгжийг дэмжин оролцуулсан.	100%
Зорилт 53. Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ							

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
120	Арга хэмжээ: 53.1 Төвлөрсөн дэд бүтцэд холбогдох боломжгүй гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг эхлүүлэх	1,171.7	Батлагдсан байршил, тоо	-		Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд 9 хэсэгчилсэн талбайд дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжиж байснаас 2024 онд 8-р хорооны Б хэсэгчилсэн талбайн төслийн гүйцэтгэгч Ивээлт цамхаг ХХК, 8-р хорооны А хэсэгчилсэн талбайн төсөл хэрэгжүүлэгч Ажнай цэгц ХХК-ийн төсөл хэрэгжүүлэх эрхийг Нийслэлийн Засаг даргын Захирамжаар тус тус цуцалж, 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нийт 7 хэсэгчилсэн талбайд дахин төлөвлөлтийн төсөл үргэлжилж байна. Төслийн хүрээнд: Төлөвлөлтийн нутаг дэвсгэр 242.15 га газрын 4633 нэгж талбар чөлөөлөхөөс 445 нэгж талбарын чөлөөлж, 484 нэгж талбарын гэрээ байгуулсан ба төслүүдийн талбайд 273 барилга, 19910 айл өрх, 7600 хүүхдийн багтаамжтай сургууль, 3350 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг, 2 эмнэлэг байгуулахаар баталсан. 2024 оны байдлаар өссөн дүнгээр 5 блок 600 айлын орон сууц ашиглалтад орж өрхүүдийн сууцны нөхцөл сайжирсан байна.	90%
121	Арга хэмжээ: 53.2 Үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад барилга угсралтын талбайг камержуулах үүрэг чиглэлийг	-	Камержуулсан барилгын төслийн тоо	-	20	Дүүргийн хэмжээнд барилгын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын 115 барилгын төслийн судалгааг гарган камергүйжүүлэлтгүй 15 барилгын талбайг илрүүлэн Теле хяналтын систем нэвтрүүлэх тухай дүүргийн Засаг даргын орлогчийн 2024 оны 8	100%

Д/д	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ТҮВШИН	ЗОРИЛТОТ ТҮВШИН	ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
	өгч хэрэгжилтийг хангуулж ажиллах					дугаар сарын 18-ны өдрийн албан бичгээр барилгын талбай болон гадна орчныг “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага MNS 6423:2019” стандартын дагуу камержуулан ажиллахыг үүрэг болгосон. Одоогоор дүүргийн хэмжээнд явагдаж байгаа 103 төслийн 101 нь теле хяналтын систем нэвтрүүлсэн байна.	
Нэмэлт 7 зорилтын хүрээнд 9 арга хэмжээний хэрэгжилт 98.9 хувь хэрэгжсэн, 3 арга хэмжээ биелэлт тооцох боломжгүй.							
НИЙТ 53 ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД 121 АРГА ХЭМЖЭЭ 97 ХУВЬ ХЭРЭГЖСЭН.							

ТАНИЛЦСАН:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА Б.ЦЭРЭН

ТАМГА
(огноо)

ТАЙЛАГНАСАН:
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БУЯНТ

ТАМГА
(огноо)